Сангийн Яам

ЯДУУРЛЫН СУДАЛГААНЫ НЭГЖ

Mongolia

ЯДУУРЛЫН СУДАЛГАА БА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ МОН01/Ю01 ТӨСӨЛ

# ӨРХ, ИРГЭДИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛЖ БУЙ ӨНӨӨГИЙН АРГАЧЛАЛЫГ СУДЛАХ, ХӨГЖЛИЙН ИЖИЛ ТӨСТЭЙ ЗАРИМ ОРНУУДТАЙ ХАРЬЦУУЛАХ НЬ

## СУДАЛГААНЫ ТАЙЛАН

**Судалгааны баг:**
Х.Гүндсамбуу, ШУ-ны доктор
Ч.Дагвадорж, доктор
Н.Тунгалаг, доктор
Я.Шуурав, доктор
Т.Бүрэнжаргал, доктор

**Туслах ажилтан:**
Т.Амартүвшин
Г.Төмөр
Д.Намхайдагва
С.Рэгзэн
Б.Бямбасүрэн

**Санаачилж, зохион байгуулсан:**
П.Бямбадорж, ЭЗНБГ-ын мэргэжилтэн, СЯ

ХҮНИЙ НӨӨЦ НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САН

Улаанбаатар хот, 2005 он

Source : http://www.undp.mn/reports/

# АГУУЛГА


**Талархал** **5**

**БҮЛЭГ 1. Удиртгал** **6**

1.1 Үндэслэл 6
1.2 Зорилго 7
1.3 Зорилт 7
1.4 Судалгаанд ашиглагдах үндсэн нэр томьёо, ойлголтууд 7
1.5 Үр дүн 8
1.6 Үр дүнд тавигдах шаардлага 8
1.7 Үр дүнг хүртэгч 8
1.8 Үр дүнг хэлэлцүүлсэн байдал 9
1.9 Судалгааны арга зүй 9
1.10 Судалгааны хамрах хүрээ 9
1.11 Зохион байгуулалт 9

**БҮЛЭГ 2. Амьжиргааны түвшин, ядуурлын онол, арга зүй, гадаад орнуудын аргачлалын судалгаа** **11**

2.1 Онол арга зүйн ном зүйд хийсэн шинжилгээ, дүгнэлт 11
2.2 Хууль эрх зүйн орчны судалгаа, дүгнэлт 13
2.3 Өнөөгийн хэрэглэгдэж буй арга аргачлалын судалгаа, дүгнэлт 14
2.4 Өмнө хийгдсэн суурь судалгааны тойм, дүгнэлт 16
2.5 Олон улсын байгууллага, хөгжлийн ижил төстэй зарим орны туршлага, судалгаа 18

**БҮЛЭГ 3. Мэдээлэл цуглуулалт, боловсруулалт** **24**

3.1 Тоон судалгаан дахь өрх, иргэдийн аж байдал 24
3.2 Чанарын судалгаа ба амьжиргааны түвшингийн хэмжүүр 31
3.3 Өрхийн амьжиргааны түвшингийн түүвэр судалгаа 36

**БҮЛЭГ 4. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлт, үнэлгээ, тооцоолол** **39**

4.1 Өрх иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлтүүд 39
4.2 Өрх иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлтүүдийн үнэлгээний аргачлал 40


Source : http://www.undp.mn/reports/

4.3 Өрхийн амжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлтүүдийн нөлөөлөл, үнэлгээ, тооцоолол 42
4.4. Амьжиргаанд нөлөөлөх бусад үзүүлэлтүүдийн ерөнхий үнэлгээ 54

**БҮЛЭГ 5. Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох шинэ аргачлал ба нийгмийн халамж хүртэгчдийн тоон өөрчлөлт 59**
5.1 Өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох шинэ аргачлал 59
5.2 Шинэ аргачлалын туршилт ба үр дүн 63
5.3 Нийгмийн халамж хүртэгчдийн тоон өөрчлөлт 66

**Хавсралт 1.** Өрхийн амьжиргааны түвшингийн талаарх санал асуулга 72

**Хавсралт 2.** Өрхийн амьжиргаа, ядуурлын асуулгаар хийсэн нэгдсэн дүн 74
**Хавсралт 3.** Өрхийн амьжиргааны түвшингийн түүвэр судалгааны асуулга 76
**Хавсралт 4.** Түүвэр судалгааны асуулга авах заавар 82
**Хавсралт 5.** Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох үндсэн үзүүлэлтүүдийн судалгааны товчоо, 5 бүлгээр 90
**Хавсралт 6.** Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох үндсэн үзүүлэлтүүдийн судалгааны товчоо, 2 бүлгээр 91
**Хавсралт 7.** Өрхийн амьжиргааны түвшингийн түүвэр судалгааны асуулга 92
**Хавсралт 8.** Өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ (хот) 94
**Хавсралт 9.** Өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ (хөдөө) 96
**Хавсралт 10.** Яам газруудаас ирсэн санал, тайлбар 98

Source : http://www.undp.mn/reports/

# ТАЛАРХАЛ

Монгол улсын нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн стратегийн баримт бичгийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээний хамрах хүрээг оновчтой болгох зорилгоор ядуу, нэн ядуу иргэдийг үнэн бодитой тогтоон тэдэнд халамжийн чиглэлээр зарцуулж буй хөрөнгийн өгөөжийг дээшлүүлэх зорилт тулгараад байгаа өнөө үед “Өрх иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлж буй өнөөгийн аргачлалыг судлах хөгжлийн ижил төстэй зарим орнуудтай харьцуулах нь” сэдвээр судалгааны ажил хийж үр дүнг нь тайлагнан илтгэж буй нь энэ билээ.

Энэхүү судалгааны ажлыг санхүүжүүлсэн НҮБХХ, ШОУХА-ийн “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих МОН01/Ю01” төсөл, судалгаанд шаардлагатай мэдээллээр цаг тухайд нь хангаж тусалсан ҮСГ-ийн Хүн ам, нийгмийн статистикийн газрын хамт олон, судалгааны ажлын явцад хамтран ажиллаж үнэтэй зөвлөгөө өгч байсан Техникийн зөвлөгөө өгөх багийн гишүүд болох НХХЯ-ны Нийгмийн хамгааллын хэлтсийн дарга Т.Батсүх, мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ, Сангийн яамны газрын орлогч дарга Б.Ганболд, Ядуурлын судалгааны нэгжийн мэргэжилтэн П.Бямбадорж, НҮБХХ-ийн эдийн засагч Г.Уянга, ҮСГ-ын ахлах мэргэжилтэн Ю.Туул, “Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр” төслийн зөвлөх Жесси Т. Понсе, Мон 01/Ю01 төслийн менежер П. Болормаа нарт судалгааны багийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Тэрчлэн судалгааны мэдээлэл цуглуулахад боломж олгон туслалцаа үзүүлсэн Өмнөговь, Өвөрхангай, Орхон аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвийн дарга, хамт олон, Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Баянгол дүүргийн Нийгмийн халамж үйлчилгээний төвийн дарга, хороодын засаг дарга, нийгмийн ажилтнуудад гүнээ талархаж байна.

*Хүний нөөц нийгмийн хамгааллын сангийн судалгааны баг*

# 1 УДИРТГАЛ

Монгол улсад зах зээлийн харилцааны шилжилтийн үед бий болсон сөрөг үзэгдлүүдийн нэг нь ядуурал юм. Монгол улсын засгийн газраас нийгмийн халамжийн бодлогын хүрээнд 48 төрлийн үйлчилгээ үзүүлдгийн 15 нь нэн ядуу иргэдэд чиглэгдэж, жилд 354200 орчим иргэнд 19,6 тэрбум төгрөгийн халамжийн үйлчилгээ үзүүлж байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд хийгдсэн ядуурлын үзлэгийн дүнгээр нийт хүн амд эзлэх ядуучуудын тоо 36%-иас буурахгүй байна. Ядуурлын хамрах хүрээг багасгах, нэн ядуу амьдралтай иргэдэд туслах зорилгоор төрөөс авч байгаа арга хэмжээг хэрэгжүүлэхэд өрх, иргэдийн амьжиргааны түвшинг бодитой тогтоож ялгавартай хандах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Амьжиргааны түвшинг буруу тодорхойлсноор олон арван хүнийг тэтгэвэр, тэтгэмжид хамруулж бэлэнчлэх сэтгэлгээг дэвэргэх, хэт хатуу хандвал нэн ядуу, бие даан амьдрах чадваргүй иргэд тусламж, дэмжлэг хүртэж чадахгүй хохирох асуудалтай тулгардаг. Сүүлийн 10-иад жилд Монгол улсын Засгийн газар, Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн яамнаас өрх, иргэдийн амьжиргааны түвшинг өртөг зардал багатай, ажиллагаа бага шаардах, хялбар аргаар тодорхойлох асуудлыг тавьж байгаа боловч өнөө хүртэл тодорхой үр дүнд хүрч чадаагүй байна. Энэ асуудлыг шийдвэрлэхэд туслах зорилгоор “Ядуурлын судалгаа, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих МОН 01/Ю01” төслөөс “Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох өнөөгийн аргачлалыг судлах, хөгжлийн ижил төстэй орнуудтай харьцуулах нь” судалгааг хийлгэж байгаа нь цаг үеэ олсон чухал ажил болж байна. Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг шинэчлэх, хялбаршуулах асуудал нь дараах үндэслэл, зорилго, чиглэлтэй.

### 1.1 Үндэслэл, шаардлага

- Засгийн газраас хүн амын хэрэглээнд үндэслэн тооцоолсон “амьжиргааны доод түвшин” гэсэн үзүүлэлтийг “ядуурлын шугам” болгон хэрэглэж иргэдийн амьжиргааны түвшинг тогтоож байна. Гэвч энэ аргыг бүрэн утгаар нь хэрэглэх аргачлал хангалтгүйгээс өрх, иргэд олноор ядууралд хамрагдах, нийгмээс хишиг хүртэх сонирхлыг төрүүлж, нийгмийн зүгээс үзүүлэх дэмжлэг, туслалцааг нэн ядуу, ядуу иргэдэд хүргэхэд хүндрэл учрах болсон;
- мөнгөн орлогын мэдээллийн тогтолцоо хангалтгүй, хүн амын нилээд хэсэг нь өрхийн болон албан бус секторын орлогоос хэрэглээгээ хангадаг манай орны хөгжлийн өнөөгийн түвшинд амьжиргааны түвшинг орлогоор хэмжиж тогтоох боломж бүрдээгүй;
- ядуурлын шугамыг үндэслэн өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох хялбаршуулсан аргачлал байхгүй,

- бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүд, баг, хороо, сумын удирдлагууд, халамж, үйлчилгээний ажилтнууд иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох хялбар, бодит байдалд тохирсон арга, аргачлалыг шаардах болсон явдал юм.

### 1.2 Зорилго

Өрх иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлж байгаа өнөөгийн арга, аргачлалыг өөрийн болон гадаад орнуудын туршлага, ололт, амжилттай харьцуулан судалж, Монголын зах зээлийн харилцааны шилжилтийн шатанд тохирсон боломжит аргыг дэвшүүлж аргачлал зөвлөмж гаргахад чиглэгдэнэ.

### 1.3 Зорилт

- Монгол улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа иргэдийн амьжиргааг тодорхойлохтой холбогдол бүхий арга, аргачлалуудыг хамруулан судлаж дүгнэлт хийх;
- Хөгжлийн ижил төстэй орнууд, олон улсын байгууллагуудаас мөрдөж буй өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлж байгаа арга, аргачлалыг судалж Монгол орны нөхцөлд тохирох хувилбарыг сонгож, өөрийн оронд хэрэглэж болох шалгуур, үзүүлэлтүүдийг нарийвчлан гаргаж судалгааны хэрэглэгдэхүүн болгон ашиглах
- Эдгээр судалгаанд үндэслэн өрх иргэдийн амжиргааны түвшинг тодорхойлох хялбар аргыг боловсруулж, аргачлал, зөвлөмж гаргах

### 1.4 Судалгаанд ашиглагдах үндсэн нэр томьёо, ойлголтууд

Энэхүү судалгаанд олон улс болон манай оронд ашиглагдаж буй 40 орчим ойлголт, ухагдахуун, үзүүлэлт, нэр томъёо, итгэлцүүрүүдийг судлан товч тайлбар зүүлт хийж дараах үндсэн ойлголтуудыг судалгааны явцад ашигласан юм.

1. “*хүн амын амьжиргааны доод түвшин”* гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг[1];
2. “*хэрэглээний доод хэмжээ”* гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг.
3. “*нийгмийн эмзэг хэсэг*” гэж бие даан амьдрах чадваргүй, тэжээн тэтгэх төрөл садангүй, ганц бие ахмад настан, тахир дутуу хүн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон нэн ядуу амьдралтай ахмад настан, тахир дутуу хүн, олон хүүхэдтэй эх /эцэг/, нэн ядуу амьдралтай хүнийг[2];
4. “*нэн ядуу хүн*” гэж тухайн хүнд ногдох орлогын хэмжээ нь амьжиргааны доод түвшингийн 40 хувиас доогуур, тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй хүнийг;
5. “*ахмад настан*” гэж эрэгтэй нь 60 ба түүнээс дээш настай, эмэгтэй нь 55 ба түүнээс дээш настай хүнийг[3]
6. “*тахир дутуу хүн*” гэж бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, тарилгын дараахь

---

[1] *Хүн амын амьжиргааны доод түвшингийн тухай хуулиас*
[2] *Нийгмийн халамжийн тухай хуулиас*
[3] *Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиас*

хүндрэл, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа, сонсгол, хэл ярианы болон бие эрхтэний тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон хүнийг[4]

7. “*хэрэглээний сагс” гэж* хүний наад захын хэрэгцээг хангахуйц бараа, үйлчилгээний багцыг тооцсон цуглуулгыг
8. “*хэрэглээний төсөв” гэж* хувь хүн ба айл гэрийн амь зуулгыг хангахуйц мөнгөний хэмжээг
9. “*туйлын ядуурал” гэж* хүний амьд явах төдийд хоол хүнс, хувцас хунар, орон гэр, дулааныхаа хэрэгцээг хангаж чадахгүй байгаа орлогын түвшинг хэлнэ.
10. “*харьцангуй ядуурал”* гэж тухайн нийгмийн амьдралын зарим хэм хэмжээ, зиндаад хүргэж чадахгүй орлогын түвшинг ойлгоно.
11. *“тэнцвэржих цэг” гэж* орлого, зарлага тэнцэж, хадгаламж бий болохгүй үеийг хэлдэг. (Энэхүү судалгааны хүрээнд ядуу хүн амын хувийн жин, нийт хүн амын хувийн жинтэй тэнцэж, харьцаа нь 1 болохыг илэрхийлж байгаа болно.)
12. “*ядуурлын шугам” гэж* хүний амьжиргааны нэн тэргүүний, зайлшгүй хэрэгцээг хангах орлогын доод хэмжээг хэлнэ. (манай улсад амьжиргааны доод түвшинг ядуурлын шугам болгон хэрэглэдэг бол энэхүү судалгаанд тэнцвэржих цэг буюу 1 гэсэн тоон утгыг ядуурлын шугам болгон авсан.)
13. *“ядууралд өртөх эрсдэл” гэж* амьжиргаанд нөлөөлөх нөхцөл, шалтгаан, хүчин зүйлсийн хэмжээг ойлгоно.
14. *”өрхийн амьжиргааны үнэлгээ”* гэж амьжиргааны чадавхийн илэрхийллийг ойлгоно. Энэхүү судалгаанд амьжиргааны үнэлгээг тэнцвэржих цэгээс ядууралд өртөх эрсдлийг хасаж тодорхойлсон.

### 1.5 Үр дүн

Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох асуудлын өнөөгийн байдал, хөгжлийн ижил төстэй орнууд, олон улсын байгууллагад хэрэглэгдэж байгаа арга, туршлагын судалгааг гаргаж, Монголын зах зээлийн харилцааны шилжилтийн шатанд тохирсон, өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох хялбар арга, аргачлал гарсан байх.

### 1.6 Үр дүнд тавигдах шаардлага

- Мөнгөн ба мөнгөн бус хүчин зүйлүүдэд үндэслэгдсэн байх
- Амьжиргааны түвшинг бодит байдлаар тодорхойлох боломжтой байх
- Амьжиргааны түвшинг тодорхойлоход шаардагдах санхүүгийн нөөцийг бодитой тооцсон байх
- Эргэх холбоо хяналтын тогтолцоо бүхий байх

### 1.7 Үр дүнг хүртэгч

Засгийн газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам, бусад яамд, агентлагууд бодлого боловсруулах түвшинд, Улсын хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, түүний орон нутаг дахь салбар, нэгжүүд, аймаг, нийслэлийн засаг, захиргааны байгууллага,

[4] *Тахир дутуу иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуулиас*

бусад төрийн ба төрийн бус байгуулагууд хэрэгжүүлэгч түвшинд, хүн ам, ядуурал, нийгмийн хамгааллын чиглэлээр суралцагч, судалгаа хийж буй оюутан сурагчид, магистр, докторантууд, судлаачид, эрдэм шинжилгээний ажилтанууд судалгааны түвшинд хэрэглэгч, үр дүнг хүртэгч нь болно.

### 1.8 Үр дүнг хэлэлцүүлсэн байдал

Судалгааны үр дүнгээр гарч буй аргачлалыг 2004 оны 12 сарын 1-ны өдөр Нийгмийн хамгааллын сайд, дэд сайд, НХХЯ, Сангийн яам, ҮСГ, НҮБХХ, Нийслэлийн ЗДТГ-ын удирдах ажилтан, мэргжилтнүүд, энэ чиглэлээр ажиллаж байгаа гадаадын зөвлөх, шинжээчид, засаг захиргааны үндсэн нэгжид ажиллаж буй мэргэжилтнүүдийг оролцуулан анхны хэлэлцүүлгийг хийсэн. Дараа нь Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны төлөөлөгчид, мэргэжлийн хүмүүс, Ерөнхий сайдын нийгмийн бодлогын зөвлөх, түүний ахалсан нийгмийн халамжийн хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэг зэрэгт удаа дараа танилцуулж, “Судалгааны зөвлөмжийг бодлогод тусгах нь” Үндэсний семинар, “Хүний хөгжлийн илтгэл - 2003”-ын сурталчилгаа, судалгааны нийслэлийн семинарын явцад хэлэлцүүлэг явуулж гаргасан санал, зөвлөмжийг тусгаж сайжруулалт хийгдсэн.

### 1.9 Судалгааны арга зүй

- *Харьцуулалт*: Өрх иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлоход хөгжиж буй орнуудад хэрэглэж буй аргуудын харьцуулсан судалгаа хийгдсэн.
- *Дүн шинжилгээ*: Манай оронд амьжиргааны түвшинг тогтоох чиглэлээр өмнө хийгдсэн судалгаануудын материалд дүн шинжилгээ хийж тэдгээрт хэрэглэсэн үзүүлэлт, үнэлгээ зэргээс дэвшилтэй, боломжтой, үр дүн нь тодорхой болсон арга, аргачлал, дүгнэлт, энэхүү судалгаанд авч хэрэглэх зүйлсийг сонгон авсан.
- *Ажиглалт*: Амьжиргааны түвшинг үнэлэх үзүүлэлт сонгох, сонгосон үзүлэлтүүд өрхийн амьжиргаатай аль хир уялдаатай болох, өнөөгийн аргачлалаар тодорхойлогдсон нэн ядуу, ядуу амьдралтай өрхүүд бодит байдалд хэрхэн нийцэж байгаа зэрэгт ажиглалт хийгдсэн.
- *Түүвэрлэлт*: Өрх иргэдийн амьжиргааны талаарх мэдээ цуглуулах, үзүүлэлтүүдийг бодитой сонгох зорилгоор хот хөдөөгийн төлөөлөл бүхий 450 өрхөд, ядуурлын дүр төрх, олон нийтийн санаа бодлыг тандах, ядуурлын хэмжүүр үзүүлэлтүүдийг тодотгох зорилгоор 650 гаруй иргэдээс түүвэр судалгаа авч боловсруулалт хийгдсэн.
- *Тэнцвэржих цэгийн арга*: Ядуурлын судалгааны цөм ойлголт болох ядуурлын шугамыг тодорхойлоход олон улсын хэмжээнд хэрэглэгддэг тэнцвэржих цэгийн аргыг судалгааны үр дүнгээр гарах аргачлалд онолын гол үндэслэл болгон авсан.

### 1.10 Судалгааны хамрах хүрээ

Хамрах хүрээг хот, хөдөөгийн төлөөллийг хангаж чадахаар байлган холбогдох хүмүүстэй ярилцсанаар 3 аймгийн 6 сум, /Өмнөговь аймгийн Булган, Даланзадгад, Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Зүүн баян-Улаан/, Улаанбаатар хотын Хан-Уул, Баянзүрх дүүргийг сонгон мэдээлэл цуглуулах, аргачлалыг турших ажлууд хийгдсэн.

### 1.11 Зохион байгуулалт

Судалгааны ажлыг Хүний нөөц нийгмийн хамгааллын сангийн судалгааны баг хийж гүйцэтгэсэн ба Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Санхүү эдийн засгийн яам, Үндэсний

статистикийн газар, НҮБХХ-ийн мэргэжилтнүүдээс бүрдсэн Техникийн зөвлөгөө өгөх баг(ТЗӨБ), “Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр” –ийн зөвлөх Жесси Т. Понсе хамтран ажиллав.

Судалгааны үе шат: Онолын судалгаа хийх, мэдээлэл цуглуулж боловсруулах, судалгааны үр дүн болох арга аргачлал боловсруулах, үр дүнг хэлэлцүүлэх, санал авах, тайлан бичих гэсэн үе шаттайгаар зохион байгуулж хийлээ.

Source : http://www.undp.mn/reports/

# 2 АМЬЖИРГААНЫ ТҮВШИН, ЯДУУРЛЫН ОНОЛ, АРГА ЗҮЙ, ГАДААД ОРНУУДЫН АРГАЧЛАЛЫН СУДАЛГАА

Source : http://www.nso.mn/reports/

Эхний ээлжинд судлагдах объектын онол арга зүйн асуудлыг судалж, дүн шинжилгээ хийх нь энэ ажлын нэг хэсэг байлаа. Энэ хүрээнд онолын чиглэл, дүгнэлтүүд, хэрэглэгдэх үзүүлэлт, ойлголтын асуудлуудыг эхний хэсэгт, хууль, эрх зүйн судалгаа дүгнэлт, хөгжлийн ижил төстэй орнууд, олон улсын байгууллагуудад хэрэглэж байгаа аргачлалын судалгааг дараагийн хэсгүүдэд нь хамруулан авч үзлээ.

## 2.1. Онол, арга зүйн ном зүйд хийсэн шинжилгээ, дүгнэлт

Ядуурлын судалгааны хандлага, чиглэлийн төлөөлөгчид болох нийгмийн Дарвинизм (Г.Спенсер, Ф.Гиддинч, П.Ж.Пурдон) нийгмийн тэгшитгэл үзэлтнүүд (К.Маркс, Ф.Энгельс, Э.Реклю), статистик-социологийн чиглэл (Ф.Ле-Пле, Ч.Бут, С.Раунтри), либериал эдийн засагчдын сургууль (Т.Маршалл, Ф.Хайек), Английн чиглэл (П.Гаундсенд), Америкийн чиглэл (М.Оршански, Х.Ваттс, Д.Фостер), Оросын чиглэл (В.И.Ленин, М.И.Туган-Барановский), XX зууны сонгодог сэтгэгчид П.А.Сорокин, М.Фондман нарын зохиол бүтээлүүд болон орчин үеийн эрдэмтэн, судлаачдын онол арга зүйн бүтээлийг судалж Монгол орны нөхцөлд тохирсон, өнөөгийн амьдралд хэрэглэгдэх ухагдахуун, ойлголтуудыг харьцуулж цаашдын судалгааны ажилдаа ашиглав.

Энэхүү ажлын хүрээнд судлагдсан онолын ном, хууль эрхзүйн актууд, бодлогын баримт бичиг зэргийг уг тайлангийн төгсгөлд номзүйн хэсэгт жагсаан харуулсан бөгөөд энэ хэсэгт бид гол агуулгыг дүгнэж тоймлон, судалгааны мөн чанартай уялдуулан дараах байдлаар авч үзлээ.

### *2.1.1. Амьжиргааны түвшний судалгааны онол, суурь үзэл баримтлалын үндэслэл ба дүгнэлт*

| Онолын чиглэл | Төлөөлөгчид | Үзэл баримтлалын агуулга |
|---|---|---|
| 1. Нийгмийн Дарвинизм | Л.Ж.Пурдон, Г.Спенсер, Ф.Гиддингс | Нийгэмд харьцангуй ба туйлын ядуурал байдаг бөгөөд нэгдэх нь үйлдвэрлэл, хэрэглээний өсөлт, өргөжилттэй, хоёр дахь нь нийгэм дэх хуваарилалтын харилцаагаар тодорхойлогдоно. |
| 2. Нийгмийн тэгшитгэл (Марксизм) | К. Маркс, Ф.Энгельс, Э.Реклю | Нийгэм дэх нийгмийн тэгш бус байдлаас ядуурал үүсдэг, өөрөөр хэлбэл үйлдвэрлэлийн хэрэгслийн хувийн өмч нь пролетаричлал, паперизацлалд (хоосрол) зайлшгүй хүргэнэ. |

| | | |
|---|---|---|
| 3.Либерализм | Т.Маршалл<br>Ф.Хайек | Хувь хүн нийгмийн төлөө төдийгүй хувийнхаа төлөө, ядуурахын эсрэг хувийн хариуцлага хүлээх ёстой. |
| 4. Ядуурлын судлаачид | И. Оршанск,<br>Х.Витс,<br>Д.Фостер- АНУ Таунсенд-Англи,<br>В.В.Берви-Флеров,<br>К.А.Пажитнов, М.И.Туган-Барановский-Орос г.м. | АНУ, Англи, Оросын нийгэм дэх нийгмийн давхраажил, түүний суурь ба доод давхраануудыг нарийвчлан судалсан. |

### *2.1.2. Амжиргааны түвшиний үндсэн үзүүлэлтүүдийн ангилал( багцлалт)*

| ОХУ | АНУ | НҮБ | Франц |
|---|---|---|---|
| 1. Нэгдсэн үзүүлэлт<br>2. Хүн амын орлого<br>3. Хүн амын хэрэглээ ба зарлага<br>4. Мөнгөн хадгаламж<br>5. Хөрөнгийн хуримтлал, орон сууц<br>6. Нийгмийн ялгарал<br>7. Бага хангамж бүхий нийгмийн давхраа | 1. Хүрээлэн буй орчлон<br>2. Хүн ам зүйн нөхцөл байдал<br>3. Ажил эрхлэлт<br>4. Хөдөлмөрийн нөхцөл<br>5. Амьдралын төвшин<br>6. Нийгмийн хангамж<br>7. Эрүүл мэнд<br>8. Боловсрол<br>9. Орон сууцны нөхцөл<br>10. Соёл, амралт, зугаа гаргалт<br>11. Тээврийн хангамж<br>12. Үндэсний батлан хамгаалалт<br>13. Иргэний эрхийн хамгаалалт | 1. Төрөлт, нас баралт, бусад хүн ам зүйн үзүүлэлт<br>2. Амьдралын эрүүл мэнд-ариун цэвэр<br>3. Хүнсний хэрэглээ<br>4. Орон сууцны нөхцөл<br>5. Соёл, боловсрол<br>6. Хөдөлмөрийн нөхцөл, ажил эрхлэлт<br>7. Хүн амын орлого, зарлага<br>8. Амьжиргааны өртөг, хэрэглээний үнэ<br>9. Тээврийн хэрэгсэл<br>10. Амралтын зохион байгуулалт<br>11. Нийгмийн хангамж<br>12. Бие хүний эрх чөлөө | 1. Хүн амын тоо, бүрэлдэхүүн, хөдөлмөрийн нөхцөл, түүнчлэн ажил хаялт<br>2. Орлогын хувиарлалт, дахин хувиарлалт, ашиглалт (анхны орлого, хөрөнгийн орлого, цалин, тэтгэврийн доод хэмжээ, ханш г.м)<br>3. Амжиргааны нөхцөл (орон сууц, амралт, хуримтлал, үнэт зүйлс г.м)<br>4. Хүн амын амьдралын түвшингийн нийгмийн тал (гэгээрэл, боловсрол, эрүүл мэнд, шилжилт, нийгмийн хэв журам г.м) |

### *2.1.3. Үндсэн ойлголтуудын агуулгын шинжилгээ, үнэлэлт*

| Суурь ойлголт | Хавсарга ойлголт | Ажлын ойлголт буюу томьёо, итгэлцүүр, индекс |
|---|---|---|
| 1. Амьдралын нөхцөл | • Газар зүйн<br>• Эдийн засгийн<br>• Нийгмийн<br>• Улс төрийн<br>• Соёлын г.м | |
| 3. Амьжиргааны төвшин | • Хүрэлцээт<br>• Хэвийн<br>• Ядуувтар<br>• Үгээгүй | |
| 4. Туйлын ядуурал | • Статистик минимум<br>• Норматив минимум<br>• Хэрэглээний сагс | Цагийн хөлсний доод хэмжээ<br>Сарын хөлсний доод хэмжээ |
| 5. Амьдрах шугам буюу ядуурлын босго | • Харьцангуй<br>• Үнэлгээний<br>• Нийгмийн<br>• Давхар индекс | |
| 6. Харьцангуй ядуурал | • Гуйлгачин<br>• Ядуу<br>• Ядуувтар | |
| 7. Ядуурлыг тооцох үзэл баримтлал | • Амьжиргааны минимум<br>• Харьцангуй ядуурал<br>• Хуримтлагдсан ядуурал | |

| | | |
|---|---|---|
| 8. Нийгмийн ялгарлын хэмжүүр | • Лоренцийн муруй<br>• Лоренцийн итгэлцүүр<br>• Жинийн итгэлцүүр | $\frac{(y_1 - x_1) + (y_2 - x_2)...(y_n - x_n)}{2} = \frac{\sum(\vert y_i - x_i \vert)}{2}$<br>$G = 1 - 2\sum_{j=1}^{n} x_j cumy_j + \sum_{j=1}^{n} x_j y_j$ |
| 9. Ядуурлын гүнзгийрүүлсэн үзүүлэлтүүд | • Ядуурлын түвшин<br>• Орлогын хомсдол<br>• Доод орлогын зааг<br>• Ядуурлын гүнзгийрлийн итгэлцүүр | |
| 10. Ядуусын соёл | • Хам соёл<br>• Дэд соёл | |
| 11. Эдийн засгийн ядуурал | • Анхдагч<br>• Хоёрдогч | |
| 12. Нийгмийн ядуурал | • Хүндэтгэх ядуурал<br>• Үл хүндэтгэх ядуурал | |

## 2.2. Хууль эрх зүйн орчны судалгаа дүгнэлт

| | | |
|---|---|---|
| 1 | Нийгмийн халамжийн тухай хууль, УБ,1998 он | 3.1.3."нэн ядуу хүн" гэж тухайн хүнд ногдох орлогын хэмжээ нь амьжиргааны доод түвшингийн 40 хувиас доогуур, тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй хүнийг;.... хэлнэ гэж хуульчилсан. |
| 2 | Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт үйлчилгээний тухай хууль, УБ, 1995 | “Эрэгтэй нь 60 ба түүнээс дээш настай, эмэгтэй нь 55 ба түүнээс дээш настай Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг, тус улсаас тэтгэвэр авдаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн ахмад настанд хамрагдана” гэж заасан. |
| 3 | Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох<br>тухай хууль, УБ, 1998 он | 3.1.1. Хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг;<br>3.1.2. Хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо, хэмжээг… хэлнэ гэж хуульчилсан. |
| 4 | Сургалтын төлбөрийг төрөөс санхүүжүүлэх тухай Засгийн газрын 158 дугаар тогтоол | ҮСГ-аас тогтоосон бүсийн амьжиргааны төвшний 60%-иас доогуур орлоготой өрхийг нэн ядуу гэж тодорхойлсон. |
| 5 | “Нийгмийн эмзэг бүлгийн болон 4 ба түүнээс дээш хүүхэд нь ерөнхий боловсролын сургуульд зэрэг суралцдаг өрхийн хүүхдэд хичээлийн хэрэглэлийг үнэ төлбөргүй олгох журам” БСШУЯ, СЭЗЯ УБ, 2000 он. Дугаар 34/ 31 | Өрхийн тэргүүлэгч нь бие эрхтний согог, оюун ухааны хомсдолтой, нэн ядуу айл өрхийг нийгмийн эмзэг бүлгийн өрхөд хамруулна гэж заасан. |
| 6 | “Хүн амын амьжиргааны түвшинг тооцох аргачилсан зөвлөмж”<br>ШУА-ийн эдийн засгийн хүрээлэн. 1994 он | Хүн амын амьжиргааны түвшинг тооцохдоо нэг хүний хүнсний хэрэглээний жилийн дундаж нормыг баримжаа болгосон байна.<br>Хүн амын амьжиргааг хэрэглээний түвшинг үндэслэн тооцох аргыг анх удаа Монголд албажуулсан байна. |
| 7 | “Ядуу амьдралтай иргэдийг тодорхойлох аргачилсан зөвлөмж”, ЭМНХЯ, УБ хот, 1997 он | Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой, тэрхүү орлогынхоо хэмжээгээр хязгаарлагдмал хэрэглээтэй хүмүүсийг ядуу гэж үзнэ гэсэн. |
| 8 | “Хүн амын амьжиргааны доод түвшинг улсын хэмжээнд тодорхойлох аргачлал” ҮСГ-ын даргын зөвлөлийн хурлаар баталсан. 1998 он. | Хүн амын амьжиргааны доод түвшин гэж хэрэглээний доод хэмжээг мөнгөөр илэрхийлснийг, хэрэглээний доод хэмжээ гэж хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэглээг хангах хүнсний болон хүнсний бус хэрэглээг сагсаар тодорхойлсон бараа, үйлчилгээний шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон тоо хэмжээг ойлгоно гэсэн. |
| 9 | “Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулах иргэдийг тодорхойлох түр журам” Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаал №48. УБ, 2004 он | “Ядуу иргэн“ гэж өрхийн нэг гишүүнд ногдох сарын дундаж орлогын хэмжээ нь ҮСГ-аас тогтоосон амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой хүнийг хэлнэ гэж заасан. |

### 2.3. Өнөөгийн хэрэглэгдэж буй арга, аргачлалын судалгаа, дүгнэлт

- Иргэд өрхийн амьжиргааны түвшинг социализмын үед түүвэрлэн сонгосон 1000-н өрхөд хөтөлж ирсэн өрхийн дансны мэдээллээр тодорхойлдог байсан бөгөөд тэр нь нууцлалтаараа “маш нууц” зэрэглэлтэй учир энгийн болон эрдэм шинжилгээний олон нийтэд хаалттай байсаар ардчилал, зах зээлтэй залгасан билээ.
- Шилжилтийн жилүүдэд хүн амын амьжиргааны түвшинг зах зээлийн эдийн засгийн нийтлэг жишгийн дагуу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын индекс, инфляцийн түвшингээр тодорхойлдог болов. ҮСГ-ын мэдээллээс үзэхэд 1991-2002 онд хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын индекс 11291,5 болтлоо өсч, харин инфляцийн төвшин 52,7-оос 1,6 болтлоо буурав. Гэхдээ энэ хоёр үзүүлэлт нь хүн амын амьжиргааны түвшинг шууд харуулахгүй, харин макро эдийн засгийн тогтворжилтыг л илэрхийлнэ.
- Түрүүчийн тогтолцоотой харьцуулахад хүн ам орлого олох эх сурвалжтай болж, бүртгэл хяналтаас гарч, орлогын ялгарал эрс нэмэгдсэнтэй холбогдон нийгмийн эмзэг хэсгийн амьжиргааны төвшинг л тодорхойлох болов.Тэгэхдээ мөн л орлогоор тодорхойлох аргад тулгуурлаж ирсэн бөгөөд өрхийн орлогын бүрэлдэхүүнд: 1. Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогууд, 2. Тэтгэвэр, тэтгэмж, 3. Барааны борлуулалт, үйлчилгээний орлого, 4. Үл хөдлөх болон үндсэн хөрөнгийн орлого, 5. Мөнгөн хадгаламж, үнэт цаасны орлого, 6. Мал аж ахуйгаас олох орлого, 7. Газар тариалангаас олох орлого, 8. Бусад орлогыг нэгтгэн өрхийн нэг гишүүнд ногдох хэмжээгээр тодорхойлох удирдамж гарсан юм. Гэвч цалин тэтгэвэр, тэтгэмжээс бусад орлого бүртгэл, хяналтад төдийлөн оролгүй үлдсэний дээр далд эдийн засаг, жижиг бизнесийн орлого, дотоод дахь олон улсын байгууллага болон төслийн орлого, гадаадаас манайхны ар гэртээ гуйвуулсан, илгээсэн орлого зэрэг нь нуугдмал хэвээрээ байлаа. Үүнээс үүдэн өрхийн амьжиргааны түвшин тодорхойгүй болж, баримжаа алдагдсан тул хүн амын амьжиргааны доод түвшинг л тодорхойлох болсон билээ.
- “Хүн амын амьжиргааны доод түвшний тухай” Монгол улсын хууль гарсны дагуу түүнийг ҮСГ тодорхойлох болсон билээ. Үүнийг эш үндэс болгон ҮСГ-ын даргын зөвлөлийн 1998 оны Х сарын хурлаар “Хүн амын амьжиргааны доод түвшинг улсын хэмжээнд тодорхойлох аргачлал”-ыг баталсан бөгөөд түүнийг өнөө хүртэл ашиглаж ирэв. Орлого, хэрэглээг хослуулсан, бүсчлэл харгалзсан түгээмэл таван зүйл бүхий энэхүү аргачлал нь шинжлэх ухааныхаа үндэслэлээр дажгүй болсон ч хэтэрхий том, олон зүйлийг багтаасан учир практикт ашиглахад хүндрэлтэй байснаас түүнийг бүхэлд нь бус, хэсэгчлэн мөрдөж ирэв.
- 2004 оны 10 сард НХХЯ-ны сайдын 78-р тушаал гарч “Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулах иргэдийг тодорхойлох журам”-ыг даган мөрдөхөөр болов. Энэхүү түр журам нь ҮСГ-ын аргачлалыг бодвол арай авсаархан, сүүлийн жилүүдэд халамжийн байгууллага, нийгмийн ажилтнуудад тохиолдсон хүндрэл, бэрхшээл, туршлага, сургамжийг тооцон үзсэнээрээ шинэлэг, практикт ашиглахад дөхөмтэй болсон юм. Нэн ялангуяа иргэдийн амьжиргааны төвшинг тодорхойлох нэгдсэн хүснэгт буюу түр журмын 4-р хавсралт нь үндсэн 6 үзүүлэлтийг оноо, итгэлцүүрээр үнэлснээрээ онцлог бөгөөд шинэлэг юм. Гэвч энэхүү түр журам нэгэн мөр ашиглагдах амжаа болоогүй байна. Түр журам нь нэг талаасаа ҮСГ-ын аргачлалын үргэлжлэл шинжтэй, нөгөө талаасаа зөвхөн зорилтот бүлэгт зориулагдсанаараа явцуухан шинжтэй учир хүлээгдэж буй үр дүн, өгөөж нь эргэлзээтэй. Үүнээс гадна

УИХ-ын 2004 оны сонгуулийн үр дүнгээр улс төрийн хоёр хүчин тэнцүүхэн суудал авч, их эвслийн засгийн газар байгуулагдсанаар эхлээд улс төрийн, дагалдаад нийгэм-эдийн засгийн шинэ нөхцөл байдал бүрэлдлээ. Засгийн газрын нийгмийн салбар, ялангуяа нийгмийн даатгал, халамж, асрамжийн чиглэлийн бодлогод нэлээд өөрчлөлт гарах нь тодорхой бөгөөд зайлшгүй болов.

Монгол улсын засгийн газрын бодлого залгамж чанараа хадгалахын сацуу хүүхдийн итгэлийн мөнгө олгохтой хамаатай болж буй тул үүнтэй уялдуулан иргэд, өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох арга, аргачлалыг шинэчлэх шаардлага үүсэв. Энэхүү нийгмийн захиалга, практик шаардлагад манай төсөл зориулагдсан болно.

Source : http://www.undp.mn/reports/

## 2.4. Өмнө хийгдсэн суурь судалгааны* тойм, дүгнэлт

| Судалгааны сэдэв | Зөвлөхүүд | Зохиогчид | Гол ач холбогдол | Давуу талууд | Сул талууд |
|---|---|---|---|---|---|
| Монголын хүний хөгжлийн илтгэл-1997. | Паулине Боерма | Хамтын зохиогчид | • Монголын хүний хөгжлийн анхны илтгэл<br>• Ядуурлын төвшингийн талаарх мэдээлэл анх удаа нийтлэгдсэн<br>• Монгол, англи хэлээр бичигдсэн | • Олон зохиогчид оролцсон<br>• Статистикийн мэдээллийг зориуд бэлтгэсэн<br>• Бусад судалгаанууд хийсэн | • Анхны илтгэл болохоор маш олон асуудал хөндсөн<br>• Ерөнхийдүү болсон<br>• Найруулга, орчуулгад зарим нэг сул тал бий |
| Монголын хүний хөгжлийн илтгэл–2000. (төрийг шинээр зүглүүлэхүй) | Х.Хулан<br>Шива Кумар<br>Петер Сталкер | Хамтын зохиогчид (12) | • Анхны сэдэвчилсэн илтгэл<br>• Ядуурлын гүнзгийрэл, түйлдлыг гаргасан | • Төрийн захиргааны шинэ удирдлагыг тод гаргасан<br>• Бичлэг, найруулга сайн болсон<br>• Нэг арга зүй, “улаан шугамаар” бичигдсэн<br>• Иж бүрэн болсон | • Шигтгээ олдсон тал бий |
| Монголын хүний хөгжлийн илтгэл-2003.(Хот, хөдөөгийн ялгаатай байдал) | Шива Кумар<br>Шахрбаноу Тажбакш | Эх материалын эх баригчид (6)<br>Редакторууд (2) | • Хот, хөдөөгийн ялгааг тодорхой гаргасан<br>• Орлогын ядуурлыг тодорхой тусгасан<br>• Жендерийн асуудлыг тусгасан. | • Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнг өргөн ашигласан.<br>• Хүний хөгжлийн индексийг бүс нутаг, хүйс, боловсрол зэргээр тодотгосон.<br>• Редакц сайн хийгдсэн. | • Эх илтгэлүүдийн чансаа янз бүр<br>• Зохиогчид цөөрч, ургальч үзэл хумигдсан |
| Амьжиргааны түвшний судалгаа 1998. | Осмөн Х.<br>Шаммад | Хамтын зохиогчид (8) | • Амьжиргааны түвшнийг гүнзгийрүүлэн судалсан.<br>• Бүсчилсэн<br>• Амьжиргааны түвшнээр 5 бүлэгт хуваасан | • Түүврийн төлөөлөл хангалттай<br>• Мэдээллийн боловсруулалт сайн<br>• Сургалт, бэлтгэлийг базаасан | • Судалгааны хэрэглэгдэхүүн нүсэр<br>• Ангиллын шалгуур сул<br>• Бичлэг, найруулга тааруу |
| Монгол улс: Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа. 2000. | Робин Мэарнс,<br>Мэера Шах<br>Д.Оуэн | Хамтын зохиогчид (12) | • Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэн судалсан<br>• Өрхийн аж байдлыг тодорхойлох жишиг үзүүлэлтийг тодорхойлсон | • Чинээлэг, боломжийн, ядуу, нэн ядуу өрхийг хөдөөний баг, сумын төв, аймаг, Улаанбаатар гэсэн 4 төвшинд гаргасан<br>• Хэвлэлийн дизайн сайн | • Түүврийн хэмжээ тодорхойгүй<br>• Өрхийн үзүүлэлтүүд харилцан адилгүй цөөн нь 5, олон нь 13<br>• Шигтгээ олдсон<br>• Судлаачдын туршлага эргэлзээтэй |

* Жич: Зарим зохиогчдын судалгааг ном зүйн байдлаар үзүүлэв

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хөдөөгийн амьжиргааны байдлыг оролцооны аргаар үнэлэх судалгаа. 2003. | Жаан Рейжмеринг | Ли юу (БНХАУ) | • Хөдөөгийн амьжиргааны байдлыг оролцооны аргаар үнэлэх судалгаа<br>• Бүлгийн судалгааг хийсэн | • Түүвэр тодорхой<br>• Бүсийн төлөөллийг гаргасан<br>• Нэг хүний гараар бичигдсэн | • Хавсралт, хүснэгтүүд мэдээлэлгүй<br>• Боловсруулалт тодорхойгүй<br>• Дэндүү богино хугацаанд хийгдсэн<br>• Түүврийн хэмжээ ихэдсэн |
| Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн судалгаа. 2004. | Алисиа Менендез Нилс Рименсинайдер | Төслийн баг | • Улаанбаатар хотын ядуурал, ба шилжих хөдөлгөөнийг судалсан | • Судалгаа иж бүрэн шинжтэй<br>• Мэдээллийн боловсруулалт сайн<br>• Техник ажлын гүйцэтгэл чанартай<br>• Монгол, Англи хэлнээ илтгэлүүд бичигдсэн | • Хоёр асуудал тусдаа бичигдсэн<br>• Дүгнэлт, бодлогын зөвлөмж тааруухан<br>• Чанарын судалгааг тавхан хоногт хийсэн |

Source : http://www.undp.mn/reports/

### 2.5 Олон улсын байгууллага, хөгжлийн ижил төстэй зарим орны туршлага, судалгаа, дүгнэлт

*Олон улсын хэмжээнд* ядуурлыг хэмждэг янз бүрийн аргууд байдаг бөгөөд эдгээр нь үндэсний хэмжээнд, бүс нутгийн хэмжээнд, өрхийн түвшинд ядуурлыг хэмжих чиглэлүүдээр ялгаатай байдаг байна. Бид судалгааны зорилгод нийцүүлэн өрх гэрийн түвшинд ядуурлыг хэмжих аргуудад голлон анхаарч судалгаа хийлээ. Бусад орны туршлагаас судлахдаа эдгээр аргад үнэлгээ өгөхийг зориогүй бөгөөд манай орны нөхцөлд авч хэрэглэж болох, бидний судалгааны зорилгод хир зэрэг нийцэж байгаа талаас нь илүү анхаарсан болно.

*Жулиа Болтвиник /"Poverty Measurement Methods – An Overview",* http://www.undp.org./poverty/publications/ ядуурлыг хэмжих аргуудыг тоймлон авч үзэж өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох дараах аргуудыг онцолжээ. Үүнд:

А) Ядуурлыг тодорхойлох нэг хэмжээст ядуурлын шугамын хувилбарууд: Ядуурлын шугамыг нормативт хүнсний сагсын 3 хувилбар, орлогын дүнгээр тогтоож өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох 4 хувилбар авч үзсэн. Хэмжих гол хувьсагч нь өрхийн нэг гишүүнд ногдох орлого, орлогыг өрхийн төсвийн судалгаанд үндэслэн хүнсний сагсны өртгөөр тодорхойлно. Ядуу гэдэг шалгуур нь ядуурлын шугамаас доогуур орлоготой байх ажээ.

Б) Ядуурлыг тодорхойлох олон хэмжээст хангагдаагүй үндсэн хэрэгцээний хувилбарууд: Хангагдаагүй үндсэн хэрэгцээг хязгаарлагдмал анхдагч, хязгаарлагдмал сайжруулсан, ерөнхий анхдагч, ерөнхий сайжруулсан гэсэн 4 хувилбараар авч үзэн тус бүрийн хэмжих үзүүлэлтүүд шалгуурыг тогтоосон.

Хязгаарлагдмал анхдагч хувилбар: хэмжүүр үзүүлэлтүүд нь өрөөний нягтрал(нэг өрөөнд 3-аас дээш хүнтэй), найдваргүй орон байр(шавар шал, муу ханын материал), цэвэр усны шугам, 7-11 насны нэг түүнээс дээш тооны хүүхэд сургуульд сурдаггүй, өрхөд 4-өөс дээш тооны тэжээлгэгчтэй байх, өрхийн тэргүүлэгч 3-аас доош жил сургуульд сурсан зэрэг бөгөөд эдгээр хэрэглээний 2 түүнээс дээшхи нь хангагдаагүй байвал нэн ядуу, нэг нь хангагдаагүй бол ядуу гэсэн шалгуур хэрэглэдэг байна.

Хязгаарлагдмал сайжруулсан хувилбар: хэмжүүр үзүүлэлтүүд нь орон байрны чанар(материал), орон байрны хэмжээ(зай), усан хангамж, сувагжуулалт, дулаан хангамж, боловсрол(хамрагдалт болон түвшин), эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, өрхийн үндсэн өмч хөрөнгө, илүү цагийн ажил зэрэг бөгөөд ерөнхий индекс –1; +1 –ийн хооронд харгалзах өртөгт нь үндэслэн тооцогддог. Ээрэг индекстэй өрхийг ядуу гэж үзнэ.

Ерөнхий анхдагч хувилбар: хэмжүүр үзүүлэлтүүд нь *орон байр*: тусдаа жорлон ваннтай байх, халаалт, чийггүй гэр орон, өөрийн орон байр, 10 дээш насны өөр өөр хүйсийн хүн бүр тусдаа унтлагын өрөөтэй байх, цэцэрлэг; *тавилга хэрэгсэл :*хүн бүрт ор, хивс, хөргөгч, угаалгын машин, телевизор; *хувцас хунар:* дулаан хувцас, шинэ-гар дамжаагүй хувцас, 2 хос гутал; *хоол хүнс:* долоо хоногт 1 удаа тусгай хоол иддэг, өдөрт 3 удаа хооллодог/хүүхэд/, насанд хүрэгчид өдөрт 2 удаа халуун хоол иддэг, өдөр бүр мах загас иддэг, *тансаг хэрэглээ:* жилд 1 удаа амралт эдэлдэг, хүүхдэд зориулсан тусгай тавилга болон тоглоом, тэмдэглэлт өдрүүд тэмдэглэдэг, хоббитой; *бусад зүйлс*: төрөл төрөгсөд найзуудаа жилд нэг удаа бэлэг өгдөг, нийтийн тээвэр хэрэглэдэг зэрэг бөгөөд 3 – аас дээш зайлшгүй хэрэглээ байхгүй бол ядуу гэж үзнэ.

Ерөнхий сайжруулсан хувилбар: өрх бүрийн ерөнхий индекс дээрхийн адил тусгай үзүүлэлтүүдийн жигнэсэн дунджаар тодорхойлогдох ба ээрэг индекстэй нь ядуу гэж тооцогдоно. Үнэлгээ нь тухайн зүйл бүхий хүн амын хувийн жинд үндэслэн тооцогддог гэжээ.

B / Мөн энэ хоёрын хосолсон буюу орлого, үндсэн хэрэгцээ хоёрыг аль алиныг нь хэрэглэсэн хэд хэдэн хувилбарыг өрхийн амьжиргааны түвшинг үнэлэхэд хэрэглэхээр санал болгосон байна.

Манайд өрхийн амьжиргааны түвшинг орлого, үндсэн хэрэглээнд тулгуурлан тооцдог аргууд өмнө хийгдсэн судалгаануудад өргөн хэрэглэгдсэн боловч эдгээр нь өртөг зардал, цаг хугацаа ихээхэн шаарддаг тул бидний судалгааны зорилгод тэр бүр нийцэхгүй байгаа ч зарим нэг аль ч улс оронд түгээмэл хэрэглэгдэх өрхийн амьжиргаатай өндөр хамаарал бүхий үзүүлэлтүүдийг бид аргачлалдаа авч хэрэглэж байгаа юм.

Хялбар, өртөг зардал, цаг хугацаа бага шаардах гэдэг утгаар нь авч үзвэл зарим нэг хөгжиж буй оронд хэрэглэгдсэн аргууд анхаарал татаж байгаа юм. Үүнд:

1. **Өрхийн ядуурлыг тодорхойлох нэг арга нь “тэнцвэржих цэг”**- ийн арга бөгөөд энэ аргаар ядуурлын шугамыг өрхийн орлого зардалтайгаа тэнцэж, хадгаламж тэгтэй тэнцэх хэмжээний орлогоор тодорхойлдог. Энэ аргын үндэс нь хадгалж чадахын тулд өрх төсвийн зарцуулалтдаа ухаалаг хандаж, оновчтой сонголт хийхэд орших юм. Лидиа Барреирас /Lidia Barreiras/ -ын (1992) тэмдэглэж хэлснээр энэ арга ядуурлын шинжилгээний үндсэн зарчим болох ёстой ажээ.

2. **Армений туршлага: Armenia’s experience with proxy means testing. (Background material by Alexsandra P.), http://www.worldbank.org./safetynets**

Армений нийгмийн халамжийн тогтолцооны шинэтгэлийн хүрээнд 1994 онд нэг индекст томьёоллоор өрхүүдийг эрэмбэлэн тэдний аж байдлын түвшинг судалгаагаар тогтоодог туршлагыг нэвтрүүлсэн. 1999 онд шинэчлэл хийгдэж дараахь томьёогоор өрхийн аж байдлыг үнэлэх болсон байна. Томьёо нь дараах хувьсагчдыг агуулдаг.

$$P = P_m \cdot P_c \cdot P_r \cdot P_h \cdot P_a \cdot P_b \cdot P_f \cdot P_i$$

- өрхийн дундаж “нийгмийн эрсдэл”
- өрхийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо
- амьдарч буй газар(суурьшилт)
- орон байрны нөхцөл
- хувийн машин
- хувийн өмч (бизнес)
- орон нутгийн засаг захиргаа (эрх бүхий байгууллага)-аас тусламж дэмжлэг авах “шаардлагатай” эсвэл “шаадлагагүй” гэж тодорхойлж өгсөн баримт

Эдгээр хувьсагчдыг өрхийн амьжиргааны түвшинд ихээхэн нөлөөтэй гэж үзэн сонгон авч тус бүрд нь оноо өгөн үржвэрээр нь өрхийн аж байдлыг тодохойлдог байна. Бид өөрийн аргачлалдаа эдгээрээс нийгмийн эрсдэл, суурьшилт, орон байрны нөхцөл, хувийн машин ба хөрөнгө, бизнес зэрэг үзүүлэлтүүдийг мөн сонгон оруулж байна.

3. **Жижиг нэгжийн сан (Small Enterprise Foundation)-гийн туршлага. Overcoming the obstacles of identifying the poorest families, Anton Simanowitz and Ben Nkuna, Sukor Kasim and Robert Gailey, http://www.sef.co.za/SEF%20&%20Develop/poverty%20target/antonbenhtm.htm**

Жижиг нэгжийн сан Африкт үйл ажиллагаа явуулж буй засгийн газрын бус байгууллага, ядуурлыг бууруулах зорилгоор жижиг зээл олгохдоо өрхийн амьжиргааны түвшинг

Source: http://www.undp.mn/reports/

хялбаршуулсан янз бүрийн аргаар тодорхойлдог байна. Үүнд:

**А/ Каспорын орон байрны индекс /Cashpor House Index/**

Онооны нийлбэрээр ядуу ядуу бус гэж ялгана.

1. 3-аас бага оноотой бол нэн ядуу
2. 4-6 оноотой бол ядуу
3. 6-аас дээш оноотой бол ядуу бус болно.

**Б/ Оролцооны аргаар өмч хөрөнгийг үнэлэх. 3 үе шаттайгаар хийгдэнэ:**

1. Хөтөлбөрт оролцох өрхийн жагсалт гаргана.
2. Орон нутгийн төлөөллөөс бүрдсэн тус бүр 5 гишүүнтэй үнэлгээ өгөх эрх бүхий 3 бүлэг зохион байгуулна. Бүлэг тус бүр ярилцлага болон ажиглалтын аргаар өрхийн өмч хөрөнгийн байдлыг төрөлжүүлэн зүйлчилж 100 хүртэлх /80, 60, 40 гэх мэт/ оноогоор дүгнэнэ.
3. Шинжилж, үнэлэн ядуу өрхийг сонгох. Ядаж 3 үнэлгээ өгөх бүлгийн үнэлгээний энгийн арифметик дунджаар [(80+60+40)/3=60] өрхийн оноог гаргана. Ядуу ядуу бус өрхийг зааглах оноо тогтоогдсон байх бөгөөд бага оноотой нь ядуу болно.

**4. Шриланкийн туршлага. Mr. C.A. Samaradikara, http://www.sef.co.za/SEF%20&%20Develop/poverty%20target/antonbenhtm.htm**

Өрхийн амьжиргааны судалгаанаас амьжиргааны түвшинг үнэлэх үзүүлэлтүүдийг сонгон 0-10 хүртэлх оноо өгөн картаар үнэлж 30-аас доош оноотойг нь ядуу гэж үздэг. Үзүүлэлтүүд нь:

1. Өрхийн сарын орлого: 50US$ = 10 оноо / 40US$ = 8 оноо /30US$ = 6 оноо /20US$ = 4 оноо /10 US$ = 2 оноо

Source: http://www.mdp.mn/reports/

2. Орон байрны чанар: Байнгын орон сууцтай = 10 оноо, Хагас байнгын = 5 оноо, түр зуурын = 0 оноо
3. Эрүүл мэнд:
   а / 100 ярдын зайд цэвэр усанд хүрэх боломжтой = 2.5 оноо, боломжгүй = 0 оноо
   б / 100 ярдын зайд бие засах газартай – устай бие засах газартай = 2.5 оноо, сайжруулалт шаардах устай бие засах газартай = 1 оноо, байхгүй = 0 оноо
   с / хүүхдийн хоол тэжээлийн байдал: орон нутгийн засаг захиргааны хүүхдийн хөгжлийн карттай бол 2,5 хүртэл оноо
   d / хүүхдийн вакцинжуулалт: орон нутгийн засаг захиргааны хүүхдийн хөгжлийн карттай бол 2,5 хүртэл оноо
4. Сургуульд хамрагдсан хүүхдийн тоо: Нийт оноо 10, сургуульд хамрагдаагүй 6-18 насны хүүхэд бүрт 2 оноо хасагдана.
5. Цахилгаанжуулалт: цахилгаантай 10 оноо, байхгүй 0 оноо

**5. UNICEF-тйн Гэр бүлийн хөгжлийн сангаас Египетэд хэрэглэсэн туршлага. http://www.sef.co.za/SEF%20&%20Develop/poverty%20target/antonbenhtm.htm**

Нэн ядуу эмэгтэйчүүдэд зээл олгохоор сонгохдоо хэрэглэдэг. Сонгох шалгуур нь:

а/ Өрх толгойлсон эмэгтэй

б/ Өрхийн нэг гишүүнд ногдох сарын орлого 12$ - оос ихгүй

в/ Өмчилж болон түрээслэж буй газар нь 0,17 акраас бага

г/ Садатын тэтгэврийн хөтөлбөр болон Нийгмийн хамгааллын яамнаас тэтгэмж авах нөхцөл хангасан байх

3 болон түүнээс дээш шалгуур хангасан нөхцөлд сонгогдоно.

**6. International Rescue Committee, SEAD Program, Sunimal Alles, http://www.sef.co.za/SEF%20&%20Develop/poverty%20target/antonbenhtm.htm**

Зааны ясан эрэгт дүрвэгсдэд 17 үзүүлэлтээр нэн ядуу(н/я), ядуу(я), ядуу бус(я/б) гэж ангилан зээл олгодог. Үзүүлэлтүүд нь:

I. Гал тогооны хэрэгсэл: /байхгүй, эвдэрсэн, хязгаарлагдмал тоотой-н/я, нэг удаагийн хэрглээ хангах тоотой- я, чанар сайтай, хэд хэдэн ком- я/б/

II. Унтаж амрах нөхцөл: /шал гудас-н/я, матрас-я, ор-я/б/

III. Хувцас: /уранхай, бохир-н/я, хагас дутуу-я, сайн-я/б/ гэх мэтчилэн

IV. Гутал

V. Хүнс

VI. Эрүүл мэндийн нөхцөл

VII. Сургууль

VIII. Орон байр

IX. Тавилга хэрэгсэл

X. Бие засах газар

XI. Ажил эрхлэлт

XII. Тээврийн хэрэгсэл

XIII. Радио

XIV. Хөргөгч

XV. Амьтан

XVI. Бизнесийн орлого

XVII. Эдийн засгийн идэвхи зэрэг үзүүлэлтээр үнэлдэг ажээ.

**7. Нигерийн туршлага. LIFT ABOVE POVERTY ORGANIZATION (LAPO). Uwa Izekor, http://www.sef.co.za/SEF%20&%20Develop/poverty%20target/antonbenhtm.htm**

Нигерт ядуурлыг тодорхойлоход хэрэглэдэг. Сонгосон 9 үзүүлэлтүүдээр 25-100 оноогоор үнэлэх ба их оноотой нь ядууд тооцогдоно.

Үнэлэх хүснэгт (Дээд ба доод оноо)

I. Албан боловсролын түвшин (12, 2)

II. 20 доош насны тэжээлгэгчид (10, 2)

III. Гэрлэлтийн байдал (10, 4)

IV. Орон байр (12, 3)

V. Байрны хэмжээ (7, 2)

VI. Мэдээлэлийн хэрэгслийн хамгийн боловсронгуй хэлбэр (12, 1)

VII. Бизнесийн ашиг орлого эсвэл хэмжээ (15, 3)

VIII. Сарын орлого (12, 5)

IX. Суурьшилт (10, 3), Дээд тал нь 100 доод тал нь 25 оноо авна.

**8. Филиппиний туршлага: 10 гол /үндсэн/ хэрэглээний үзүүлэлт**

Амьжиргаа залгуулах түвшинд

- Хүнс тэжээл
- Эрүүл мэнд
- Ус, усан хангамж
- Хувцас

Хамгаалалттай түвшинд

- Орон байр
- Энх амгалан байдал/ төрийн хамгаалал
- Орлого мөнгөн эх үүсвэр

Хүрэлцээт түвшинд

- Суурь боловсрол, бичиг үсэг
- Нийгэмд эзлэх байр суурь
- Гэр бүлийн халамж

Хэрэглээний үзүүлэлтүүдийн стандарт:

I. **Хүнс тэжээл:** Хүүхэд төрөх үеийн жин ядаж 2,5 кг байх, 5 хүртэлх насны хүүхдүүдийн жин хэт бага биш байх, жирэмсэн болон хөхүүл эхчүүдийн иод ураны баяжмалаар хангагдах байдал, ядаж 4 сар хөхөөр хооллож байгаа хүүхдүүд

II. **Эрүүл мэнд:** Үйлчилгээг мэргэжсэн хүмүүс үзүүлдэг, 0-1 насны хүүхдүүд бүрэн

Source : http://www.undp.mn/reports/

вакцинжсан байдал

III. **Ус, усан хангамж:** 250 метрт эсвэл 10 мин явж хүрэх газарт ундны устай, жорлонтой байх

IV. **Хувцас:** Хавар зун, намар өвлийн гэрт болон гадуур өмсөх 3 ээлжийн хувцастай байх

V. **Орон байр:** Өөрийн, түрээсэлсэн эсвэл хамтран эзэмшдэг, 5 доошгүй жил амьдрахаар

VI. **Энх амгалан байдал/ төрийн хамгаалал:** Иргэний гэмт хэрэгт өртөхөөргүй, өмч хөрөнгийн гэмт хэрэгт өртөхөөргүй, сүүлийн жилүүдэд байгалийн гамшигт өртөөгүй, сүүлийн жилүүдэд дайны хор уршигт өртөөгүй

VII. **Орлого мөнгөн эх үүсвэр:** Өрхийн тэргүүлэгч ажилладаг, өрхийн бусад насанд хүрсэн гишүүд ажил эрхэлдэг, амьжиргааны баталгаажих доод түвшинд орлого нь хүрдэг

VIII. **Суурь боловсрол бичиг үсэг:** 3-6 насны хүүхдүүд сургуулийн өмнөх цэцэрлэгт хамрагдсан, 7-18 насны хүүхдүүд сургуульд сурдаг, Өрхийн 10 дээш настай гишүүд бичиг үсэгтэй эсэх

IX. **Нийгэмд эзлэх байр суурь:** Өрхийн ядаж 1 гишүүн албан ёсны олон нийтийн байгууллага, нийгэмлэгт хамрагддаг, сонгуульд санал өгөх бололцоотой байх

X. **Гэр бүлийн халамж:** 15-аас доош насны нэг ч хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртөөгүй байх, 7-оос доош насны нэг ч хүүхэд хараа хяналтгүй орхигдоогүй байх

**9. Вьетнамын туршлага: Concepts, contents and Measurement of Poverty in Vietnam, http://www.unescap.org/stat/meet/povstat/pov7-vnm.asp**

1. Хүнсний ядуурлын шугамыг 12 зүйл оруулсан хүнсний сагсын 8-10%-иар тогтоох
2. Ядуурлын шугамыг будааны өртөгт шилжүүлсэн орлогоор нь өлсгөлөн, ядуу гэж ангилан хот хөдөөгийн ялгаатай тогтоох
3. Ядуурлын шугамыг доогуур ба арай өндөр гэсэн 2 ангилалтайгаар хүнсний болон хүнсний бус барааг оролцуулсан сагсаар тодорхойлох гэсэн 3 аргыг хэрэглэдэг

**10. Казакстан болон зүүн европын социалист орнуудын туршлага http://www.undp.org/dpa/publications/choicesforpoor, Jaroslav Gorniak, Poverty in Transition: Lessons from Eastern Europe and Central Asia, http://www.unescap/stat/meet/povstat/pov7-kaz.pdf, Measurement of Poverty in Kazakhstan.**

Шилжилтийн үеийн ядуурлын асуудал түүнийг UNDP-ийн аргачлал - LSMS-ээр хэмжих тухай асуудлуудыг хамарсан. Манай оронд байгаа судалгааны материалтай ижил түвшинд хийгдсэн учир бид өөрийн судалгаанд харгалзан үзэж байгаа.

Source: http://www.unpan.org/

# 3 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ, БОЛОВСРУУЛАЛТ

Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох арга, аргачлалыг боловсруулахын тулд хийгдсэн тоон болон чанарын судалгаа нь ажлын үр дүн, түүний үндэслэлийг сайжруулах нэг чухал хүчин зүйл боллоо.

## 3.1 *Тоон судалгаан дахь өрх, иргэдийн аж байдал.*

(мэдээ цуглуулалт, боловсруулалт, дүгнэлт)

Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны тоон мэдээлэл цуглуулах үйл ажиллагааны хүрээнд Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүн, өмнө хийгдсэн өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанууд, ҮСГ, НХХЯ, СЭЗЯ-наас гаргасан тоо мэдээлэлүүдийг цуглуулж боловсруулалт хийлээ. Энд ашиглагдсан материалууд нь:

1. Хүн ам, орон сууцны тооллогын нэгдсэн дүн, 2000 он, ҮСГ
2. Хүн амын хэтийн тооцоо, 2003 он,  ҮСГ
3. Ядуурлын үзлэгийн дүн 1997,1999, 2001 он, НХХЯ
4. Нийгмийн халамжийн  сангийн тайлан 1997-2003 он, УНХГ
5. Амьжиргааны түвшингийн түүвэр судалгаа-1998 он, ҮСГ, Дэлхийн банк
6. Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түүвэр судалгаа, 2002-2003, ҮСГ, Дэлхийн банк,
7. Хөдөөгийн амьжиргааны байдлыг оролцооны аргаар үнэлэх судалгаа, 2003 он, ҮСГ. ХААХОУС/ IFAD/
8. Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа 2000 он, ҮСГ,   Дэлхийн банк
9. Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөний судалгаа 2004 он, НХХЯ, НҮБХХ, МУИС-ийн Хүн амын сургалт судалгааны төв.
10. Хүний хөгжлийн илтгэл 1997, 2000, 2003 зэрэг болно.

Эдгээрээс өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлоход үндэс болж чадахуйц 2 судалгааг сонгож, шинжилгээ, дүгнэлт хийсэн.

### *3.1.1. Хүн амын тоо, байршил, бүтцийн судалгаа*

10 жилд нэг удаа явагддаг Монгол улсын хүн амын тооллогын дүн нь өрх, иргэдийн аж амьдралын байдлыг нарийвчлан гаргадаг, хаяг, үр дүн нь тодорхой, нарийвчилсан судалгаа

Source : http://www.mongolia.../reports/

хийх боломжийг бий болгосон олон давуу талтай. Иймээс 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын материалыг судалгааны нэг үндэслэл болгон авч үзлээ.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын материалыг үндэслэж улсын нийт хүн амын тоо, байршилт, ам бүлийн тоо, насны бүтэц, хөдөлмөр эрхлэлт, орон сууцны байдал, гэр бүлийн бүтэц, эмзэг бүлгийн иргэдийн тоон мэдээллийг нарийвчлан судалж өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлоход нөлөөлөх хэмжүүрүүдийг сонгон авах үндэслэл болгосон юм.

### 1. Нийт хүн амын тоо

Улсын нийт хүн амын тооноос хот, хөдөөгийн суурьшилтын байдал, хүн ам зүйн ачаалал, насны бүтэц, хүйс зэрэг олон үзүүлэлтүүд тодорхойлогддог. 2000 оны тооллогоор манай улсад 2373.4 мянган хүн тоологдсны 1177, 9 мянган нь эрэгтэй, үлдсэн нь эмэгтэйчүүд байлаа. Энэ нь манай улсын хүн амын дотор хүйсийн харьцаа тэдийлэн алдагдаагүй гэсэн үг юм. Харин суурьшилтаар нь авч үзвэл сүүлийн жилүүдэд бий болсон шилжилт хөдөлгөөн их нүүдлийн үр дүнд төвлөрөл явагдаж, хотын хүн амын тоо хөдөөгийнхнөөс өсөх хандлагатай байгаа нь ажиглагдлаа.

*Хүснэгт № 3-1*

**Хүн амын тоо, хүн ам зүйн ачаалал, нас хүйсний харьцаа**

| Хүн амын тоо, хүн ам зүйн ачаалал, нас хүйсний харьцаа | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Нас | Хот | | | Хөдөө | | | Бүгд | | |
| | эрэгтэй | эмэгтэй | нийт | эрэгтэй | эмэгтэй | нийт | эрэгтэй | эмэгтэй | Нийт |
| Хүн амын тоо | | | | | | | | | |
| 0-14 | 223585 | 222255 | 445840 | 204506 | 198775 | 403281 | 428091 | 421030 | 849121 |
| 15-59 | 404965 | 428350 | 833315 | 289933 | 276829 | 566762 | 694898 | 705179 | 1400077 |
| 60+ | 28531 | 36830 | 65361 | 26461 | 32473 | 58934 | 54992 | 69303 | 124295 |
| *Нийт* | *657081* | *687435* | *1344516* | *520900* | *508077* | *1028977* | *1177981* | *1195512* | *2373493* |
| Хүн ам зүйн ачаалал | | | | | | | | | |
| *Нийт* | *62.3* | *60.5* | *61.3* | *79.7* | *83.5* | *81.6* | *69.5* | *69.5* | *69.5* |
| Хүүхэд | 55.2 | 51.9 | 53.5 | 70.5 | 71.8 | 71.2 | 61.6 | 59.7 | 60.6 |
| Өндөр настан | 7.0 | 8.6 | 7.8 | 9.1 | 11.7 | 10.4 | 7.9 | 9.8 | 8.9 |

*Эх сурвалж:: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Монгол Улс дахь хүйсийн ялгаатай байдал: сэдэвчилсэн судалгаа, ҮСГ*

Хүн ам зүйн ачааллын тухайд “тэжээлэгчийн үүргийг “ ихэвчлэн хүүхдүүд гүйцэтгэж байгаа бөгөөд хот, хөдөөгийн ялгаа тэдийлэн харагдахгүй байна. (Хүснэгт № 3-1). Харин өндөр настны хувьд хөдөөд хотынхоос арай олон байгаа нь ажиглагдлаа.

### 2. Хүн амын суурьшилт

Хүн амын амьдрах орчин, төв суурин газраас алслалтын байдал нь амьжиргаанд нөлөөлөх хандлагатай байгааг өмнөх хэсэгт тэмдэглэсэн. Иймд хүн амыг суурьшилтаар нь ангилахдаа Улаанбаатар, аймгийн төвийг “хот”-д, сумын төв, тосгон, хөдөөгийн багт амьдрагчдыг “хөдөө”-д хамруулан авч үзлээ.

Source: http://www.undp.mn/reports/

*Хүснэгт № 3-2*

**Хүн амын байршил**

| | | Улаанбаатар | Аймгийн төв | Сумын төв | Хөдөө | Нийт өрх |
|---|---|---|---|---|---|---|
| Өрхийн | Тоо | 161273 | 118104 | 85281 | 176491 | 541149 |
| | Хувь | 29.80 | 21.82 | 15.76 | 32.61 | 100.00 |
| Хотод | Тоо | 279377 | | 261772 | | |
| Хөдөөд | Хувь | 51.63 | | 48.37 | | |

Нийт өрхийн 29,8 хувь нь хотод, 21,82 хувь нь аймгийн төвд, 15,76 хувь сумын төвд, 32,61 хувь нь хөдөөд амьдарч байна.

### 3. Орон сууцны нөхцөл

Орон сууцны төрлийг гэр, байшин, нийтийн байр зэргээр ангилж хот, хөдөөгийн ялгаатай байдлаар нь тооллогын дүнд нэгтгэсэн байна. Улсын нийт өрхийн 50.9 хувь нь гэрт амьдарч байхад Улаанбаатарт гэрт амьдрагчид 21.8 хувийг эзлэж байна. Харин хөдөөгийн багийн хүн амын 90 хувь нь гэрт амьдарч байна.

*Хүснэгт №3- 3*

**Өрх, сууцны төрөл, байршлаар, дүнд эзлэх хувиар**

| | Бүгд | | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Хувь | Хөдөө | Сумын төв | Тосгон | Аймгийн төв | Улаан-баатар |
| Бүгд | 541.1 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Гэр | 275.6 | 50.9 | 89.9 | 56.7 | 26.1 | 37.5 | 21.8 |
| Байшин | 265.5 | 49.1 | 10.1 | 43.3 | 73.9 | 62.5 | 78.2 |
| Сууцны тусдаа байшин | 133.9 | 24.7 | 8.9 | 35.0 | 39.3 | 29.5 | 29.9 |
| Нийтийн сууцны байшин доторх сууц | 119 | 22.0 | 0.6 | 5.9 | 30.2 | 30.2 | 44.8 |
| Нийтийн байр | 8.4 | 1.6 | 0.4 | 1.4 | 3.1 | 1.7 | 2.5 |
| Сууцны бус | 3.4 | 0.6 | 0.1 | 0.9 | 1.2 | 0.9 | 0.8 |
| Бусад | 0.8 | 0.2 | 0.1 | 0.1 | 0.1 | 0.2 | 0.2 |

*Эх сурвалж:: 2000 оны Хүн ам, орон сууцны тоollого: Үндсэн үр дүн, ҮСГ*

Судалгаанаас хот, хөдөөд сууцны төрөл, түүнд амьдардаг өрхийн тоо харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Эндээс өрхийн амьжиргааны нэг гол үзүүлэлт болох орон сууцны байдлыг хот, хөдөөгийн ялгаатайгаар судлах нь зүйтэй гэсэн дүгнэлт хийж болох юм.

### 4. Өрхийн ам бүлийн тоо, хүн ам зүйн ачаалал

Өрхийн орон сууцны төрөл, суурьшилтаас гадна нэг өрхөд амьдарч байгаа ам бүлийн тоо нь тэр айлын амьжиргааны чадавхийг илэрхийлэх бас нэг гол үзүүлэлт болдог.

*Хүснэгт №3-4*

**Өрхийн тоо, ам бүл, байршлаар**

| Ам бүлийн тоо | Бүгд | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | Өрхийн тоо | Дунд эзлэх хувь | Өрхийн тоо | Дүнд эзлэх хувь | Өрхийн тоо | Дүнд эзлэх хувь |
| 1 | 35410 | 6.5 | 16388 | 5.5 | 19022 | 7.8 |
| 2 | 57409 | 10.6 | 28375 | 9.6 | 29034 | 11.9 |
| 3 | 96857 | 17.9 | 51835 | 17.5 | 45022 | 18.4 |
| 4 | 123916 | 22.9 | 69370 | 23.4 | 54546 | 22.3 |
| 5 | 95644 | 17.7 | 53993 | 18.2 | 41651 | 17.0 |
| 6 | 65637 | 12.1 | 37084 | 12.5 | 28553 | 11.7 |
| 7 | 32546 | 6.0 | 18296 | 6.2 | 14250 | 5.8 |
| 8 | 17502 | 3.2 | 10206 | 3.4 | 7296 | 3.0 |
| 9 | 8317 | 1.5 | 5155 | 1.7 | 3162 | 1.3 |
| 10+ | 7911 | 1.5 | 5696 | 1.9 | 2215 | 0.9 |
| **Бүгд** | **541149** | **100.0** | **296398** | **100.0** | **244751** | **100.0** |

*Эх сурвалж: Монгол Улсын хүн ам хорьдугаар зуунд, 2000 он, ҮСГ*

Манай улсын нийт өрхийн 22.9 хувь нь 4 ам бүлтэй байгаа нь хамгийн өндөр хувийн жинг эзэлж байна. Харин 3 ба 5 ам бүлтэй өрхийн хувийн жин ойролцоо 17 хувьтай байна. Хот, хөдөөд өрхийн ам бүлийн тооны ялгаа төдийлэн харагдахгүй байна. Иймээс өрх, иргэдийн амьжиргааны түвшинг ам бүлийн тоотой нь уялдуулан судлахдаа хот, хөдөөгөөр нь салгаж үзэх шаардлагагүй, учир нь хот хөдөөгийн өрхийн тархалт хэвийн болно.

**5. Өрхийн гишүүдийн боловсролын түвшин**

Өрхийн ам бүлийн тооноос гадна боловсрол зэрэг чанарын үзүүлэлт тэдний амьжиргаанд нөлөөлдөг.

*Хүснэгт № 3-5*

**Хүн амын боловсоролын түвшин , %**

| Үзүүлэлтүүд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд |
|---|---|---|---|
| **Боловсролын түвшин** | 100.0 | 100.0 | 100.0 |
| Багаас доош | 3.8 | 14.0 | 5.5 |
| Бичиг үсэг мэддэг | 2.7 | 8.0 | 3.6 |
| Бичиг үсэг мэддэггүй | 1.1 | 6.0 | 1.9 |
| Бага | 14.9 | 23.9 | 16.3 |
| 4-8-р анги | 33.2 | 19.0 | 30.9 |
| 9-10-р анги | 20.7 | 17.3 | 20.1 |
| Техник мэргэжлийн | 5.9 | 3.6 | 5.5 |
| Тусгай дунд, бүрэн бус дээд | 9.2 | 11.7 | 9.6 |
| Дээд | 12.3 | 10.6 | 12.0 |

Тооллогын дүнгээс үзэхэд дээд боловсрол эзэмшигчид нийт хүн амын дөнгөж 12 хувийг эзлэж байхад бичиг үсэг мэддэггүй буюу бага боловсролтой хүний хувийн жин 27 орчим хувь байгаа нь өмнөх үзүүлэлтээс даруй 2 дахин их байна. Нийт хүн амын 50 гаруй хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсрол эзэмшжээ. Эндээс хүн амын дунд боловсролын түвшингийн нилээд

Source : http://www.

ялгаа байгаа нь харагдаж байна. Энэ нь өрх, иргэдийн амьжиргаанд боловсролын түвшин хэрхэн нөлөөлж байгааг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүргэлээ.

**6. Өрхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал**

Түүнчлэн өрхөд ажил хийж орлого олдог хүний тоо ч тэдний амьжиргаанд маш ихээр нөлөөлдөг. Гэхдээ ажил хийдэг хүний тооноос гадна ямар мэргэжлийн ажлыг, аль салбарт хийдэг нь цалин хөлс орлогод нөлөөлдөг нэг үзүүлэлт болдог байна.

*Хүснэгт №3-6*

**Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн судалгаа,%**

| Үзүүлэлтүүд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд |
|---|---|---|---|
| **Эдийн засгийн идэвх** | 100.0 | 100.0 | 100.0 |
| Эдийн засгийн идэвхтэй | 81.9 | 49.9 | 76.6 |
| Ажиллагсад | 64.7 | 40.3 | 60.7 |
| Ажилгүйчүүд | 17.2 | 9.6 | 15.9 |
| Эдийн засгийн идэвхгүй | 18.1 | 50.1 | 23.4 |
| **Ажил эрхлэлтийн байдал** | 100.0 | 100.0 | 100.0 |
| Ажил эрхэлдэг | 64.7 | 40.3 | 60.7 |
| Үүнээс | | | |
| Гэрээгээр ажиллагч | 41.0 | 55.7 | 42.6 |
| Ажил олгогч | 2.2 | 1.3 | 2.1 |
| Хувиараа ажил эрхлэгч | 54.3 | 39.4 | 52.7 |
| Хоршооллын гишүүн | 0.5 | 0.5 | 0.5 |
| Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч | 1.8 | 2.9 | 1.9 |
| Бусад | 0.1 | 0.1 | 0.1 |

*Эх сурвалж:: 2000 оны хүн ам, орон сууцны тооллого: Монгол Улс дахь хүйсийн ялгаатай байдал: сэдэвчилсэн судалгаа, ҮСГ*

Ажил эрхлэлтийн түвшнээрээ эрэгтэй эмэгтэйчүүд харилцан адилгүй бөгөөд эрэгтэйчүүд нь дүнд эзлэх хувиараа 24,4 (64,7-40,3) нэгжээр илүү байна. Гэхдээ гэрээгээр ажилагсадын хувьд эмэгтэйчүүд нь 14,7(55,7-41,0) нэгжээр илүү байхад хувиараа аж ахуй эрхлэгчдийн хувьд эрэгтэйчүүд нь 14,9(54,3-39,4) нэгжээр илүү буй нь сонирхууштай үзүүлэлт юм. Бүхэлд нь авч үзвэл өнөөгийн монголын нийгмийг ажил эрхлэлтээрээ эмэгтэйчүүд нуруундаа үүрч байна.

Дээр тодорхойлогдсон үзүүлэлтүүд иргэдийн амьжиргааны түвшинд хэрхэн нөлөөлж байгааг сонгосон аймгуудад хийсэн сорилын судалгаа, ҮСГ-аас хийсэн өрхийн орлого зарлагын судалгаа, амьжиргааны түвшингийн түүвэр судалгааны дүнд үндэслэн судалж үзлээ. Эдгээрээс хамгийн сүүлд хийгдсэн *Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түүвэр судалгаа 2002-2003-ны* дүнгээр гарч ирсэн зарим үр дүнг энэхүү судалгаанд хэрэглэхээр сонгон авсан юм.

### *3.1.2. Хүн амын тоон үзүүлэлтүүд ба амьжиргааны түвшингийн харилцан хамаарлын судалгаа.*

Үндэсний статистикийн газрын *Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түүвэр судалгаа 2002-2003* нь НҮБХХ, Дэлхийн банкны тусламж, дэмжлэгтэй, 3300 гаруй өрх, 2002-2003 оныг хамарч олон улсын аргачлалаар хүн амын амьжиргааны түвшин, ядуурлын хамгийн сүүлийн үеийн мэдээ, материалыг цуглуулж, мэргэжлийн байгууллага, хүмүүсээр боловсруулалт хийлгэсэн, 2004 оны 12 сард олон нийтэд зарлагдсан ядуурал, өрх, иргэдийн амьжиргааны талаар гарсан хамгийн шинэ мэдээлэл болж байна. Энэ судалгаа нь Монгол орны нийт иргэдийн

Source: http://www.ndpmn.reports/

амьжиргааны түвшин, орлого, зарлага, хэрэглээний байдлыг багтаасан төдийгүй ядуурлын өнөөгийн дүр төрхийг нийтэд мэдээлснээрээ бидний энэхүү судалгаатай уялдаж байна.

Энэхүү судалгааны дүнгээс үзэхэд Манай улсын хүн амын 36.1 хувь нь амьжиргааны түвшингээс доогуур орлоготой амьдарч ядуу гэсэн ангилалд багтаж, энэ байдал хот хөдөөд харилцан адилгүй байгаа нь тогтоогджээ.

*Хүснэгт №3-7*

**Амьжиргааны түвшингийн хот, хөдөөд ялгаатай байдал,%**

| дд | Үзүүлэлт | | Амьжиргааны түвшингээс доогуур орлоготой иргэдийн хувийн жин |
|---|---|---|---|
| 1 | Улсын дундаж | | 36.1 |
| | Үүнээс: | Хот | 30.3 |
| | | Хөдөө | 43.4 |

*Эх сурвалж: ӨОЗАТС 2002/ 2003*

Хүснэгтээс өрх, иргэдийн амьжиргааны байдал хот, хөдөөд харилцан адилгүй, орон нутагт амьдрагчид ядууралд өртөх нь их байгаа харагдаж байна. Хөдөөгийн хүн амын 43.4 хувь нь амьжиргааны түвшингээс доогуур орлоготой амь зууж байгаагийн үндсэн шалтгааныг чанарын судалгаагаар тодруулан үзэхэд ажил хийх боломж муу, эрчим хүч, цахилгааны эх үүсвэр хангалтгүй, бүтээгдэхүүн борлуулах, үйлчилгээ үзүүлэх зах зээл бага, зам харилцаа, мэдээлэл муу хөгжсөн зэргээр тайлбарлагдаж байгаа юм. Түүнчлэн сумын төвд ядуурал нэмэгдэх хандлагатай байгаа нь байгаль, цаг уурын бэрхшээлээс малгүй болсон, хот, аймгийн төв нүүх чадваргүй иргэд суман төв бараадлагтай холбоотой гэж ярьцгааж байна.

*Хүснэгт №3-8*

**Суурьшилт, ядуурлын судалгаа,%**

| | | Улсын дундаж | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Улаан-баатар | Аймгийн төв | Сумын төв | Хөдөө |
| 2 | Ядуучуудын хувийн жин | 100 | 22,8 | 23,7 | 20.0 | 33,6 |
| 3 | Ядуурлын хамралтын хүрээ % | 36.1 | 27.3 | 33.9 | 44.5 | 42.7 |

Сумдын нийт хүн амын нь 44.5 ядуу амьдарч буй нь улсын нийт ядуучуудын 20 хувийг эзлэхэд хүрчээ. Хөдөөгийн багт амьдарч байгаа өрхийн 42.7 хувь нь ядуу байна. Харин аймгийн төв, нийслэлд ядуурлын түвшин харьцангүй бага байна. Энэ нь дээрх газруудад дэд бүтэц илүүтэй хөгжсөн, ажил хайх, мэдээлэл авах боломж илүүтэй, бүтээгдэхүүн борлуулах, үйлчилгээ үзүүлэх зах зээл харьцангүй өргөн, бэлэн мөнгөний эрэлт, нийлүүлэлт сайн зэргээр тайлбарлагдаж болно.

Амьжиргааны түвшинд ам бүлийн тоо шууд нөлөөлдөг нь судалгаагаар тогтоогджээ. Ам бүлийн тоо нэмэгдэх тутам ядуу амьдралтай өрхийн тоо өсөж байна.

*Хүснэгт №3-9*

**Өрхийн ам бүлийн тоо, ядуурлын судалгаа,%**

| | | Улсын дундаж | Өрхийн ам бүлийн тоо | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 дээш |
| 1 | Ядуу өрхийн хувийн жин | 100.0 | 0 | 0.9 | 5.6 | 15.0 | 21.2 | 21.2 | 15.7 | 20.5 |
| 2 | Ядуурлын хамрах хүрээ | 36.1 | 1.2 | 7.4 | 15.5 | 23.5 | 34.4 | 48.5 | 57.4 | 69.4 |
| 3 | Хүн ам зүйн ачаалал | 43.3 | 61.4 | 46.8 | 47.6 | 42.2 | 43.4 | 44.0 | 43.2 | 42.4 |

*Эх сурвалж: ӨОЗАТС 2002/03*

5 хүртэл ам бүлтэй өрх ядууралд өртөх нь харьцангуй бага байгаа бол 6-гаас дээш ам бүлтэй өрхүүдийн 48.5-69.4 хувь нь ядуу амьдралтай байна. Улсын нийт ядуу хүмүүсийн 57.4 хувь нь 6–гаас дээш ам бүлтэй өрхөд амьдарч байна. Энэ нь өрхийн ам бүлийн тооноос өрхийн амьжиргааны түвшин хамаарч байна гэсэн үг юм.

Боловсролын түвшингээс тухайн өрхийн амьжиргааны түвшин шууд хамаардаг нь судалгаагаар тогтоогдлоо. Дээд боловсролтой гишүүд бүхий өрхийн ядуурлын хамрах хүрээ 11.6% байхад боловсролгүй буюу бага боловсролтой өрхөд 45 орчим хувь байна.

*Хүснэгт №3-10*

**Боловсролын түвшин, ядуулын судалгаа,%**

| | | Улсын дундаж | Боловс-ролгүй | Бага боловсрол-той | Бүрэн бус дунд | Бүрэн дунд | МСҮТ-ийн | Тусгай мэргэж-лийн дунд | Дээд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | АДТ-өөс доош орлоготой хүн амын хувийн жин | 100 | 5,4 | 17,9 | 34,6 | 18,2 | 11,5 | 8,8 | 3,2 |
| 3 | Ядуурлын хамрах хүрээ | 36,5 | 45,8 | 45,6 | 45,5 | 34,9 | 40,7 | 23,4 | 11,6 |

*Эх сурвалж: ӨОЗАТС 2002/03*

Нийт ядуучуудын 90 орчим хувь нь боловсролгүй болон бага, дунд боловсролтой өрхөд амьдарч байна.

Хөдөлмөр эрхлэлтээс өрхийн амьжиргааны түвшин хамаардаг гэдгийг ӨОЗАТС 2002/03-ны энэ дүнгээс харж болох юм. Боловсрол мэдлэгтэйгээс гадна түшигтэй, үйл ажиллагаа нь тогтмолжсон газар ажилладаг тэргүүлэгчтэй өрхийн амьжиргааны түвшин сайн байхад ажилгүй, хөдөлмөр эрхлэх боломжгүй өрхийн амьжиргаа нь муудаж ядууралд өртөх нь эрс нэмэгддэг байна.

Source : http://www.undp.mn/reports/

*Хүснэгт №3-11*

**Хөдөлмөр эрхлэлт, ядуурлын судалгаа,%**

| | | Улсын дундаж | Мал-чин | Хувийн салбарт | Улсын байгууллагад | ҮҮГ | Ажилгүй | Тэтгэвэрт | Хөдөлмөр эрхлэх боломжгүй |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | АДТ-өөс доош орлоготой хүн амын хувийн жин | 100 | 28,5 | 23,2 | 12,8 | 1,8 | 4,0 | 15,6 | 13,8 |
| 3 | Ядуурлын хамрах хүрээ | 36,5 | 39,2 | 34,7 | 25,9 | 21,6 | 48,7 | 35,7 | 51,4 |

Улсын байгууллагад ажилладаг тэргүүлэгчтэй өрхийн 26 хувь нь ядуурлад өртөж байхад ажилгүй буюу хөдөлмөр эрхлэх боломжгүй өрхийн гишүүдтэй өрхийн 48.7-51.4 хувь нь ядуурлад өртөж байгаа гэсэн судалгаа гарсан байна.

Өрхийн амьжиргааны байдал нь тэдний орон сууцны нөхцлөөс хамаардаг болох нь судалгаанаас ажиглагдаж байна. Гэхдээ орон сууцны нөхцөл хот, хөдөөд ялгавартай байдлаар амьжиргаанд нөлөөлж байна. Хотод орон сууцны нөхцөл амьжиргаанд нөлөөлөх нь их байхад хөдөө орон нутагт харьцангуй нөлөөлөл багатай байна.

*Хүснэгт №3-12*

**Орон сууцны нөхцөл, ядуурлын судалгаа,%**

| | | Хот | | | | Хөдөө | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Гэр | Байшин | Тохилог | Бусад | Гэр | Байшин | Тохилог | Бусад |
| 2 | АДТ-өөс доош орлоготой хүн амын хувийн жин | 15,3 | 23,3 | 7,3 | 0,7 | 37,8 | 13,8 | 1,9 | 0,1 |
| 3 | Ядуурлын хамрах хүрээ | 47,5 | 33,9 | 14,3 | 31,2 | 41,9 | 48,5 | 41,8 | 20,0 |

Хотын гэрт амьдардаг өрхүүдийн ядуурлад өртөлт 47.5 хувь байхад тохилог сууцанд амьдрагчдын 14.3 хувь нь ядуу амьдралтайд тооцогдож байна.

## 3.2. Чанарын судалгаа ба амьжиргааны түвшинг тодорхойлох хэмжүүрүүд (мэдээ цуглуулалт, боловсруулалт, дүгнэлт)

Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлоход тоон мэдээллээс гадна ядуурлын түвшин, шалтгааныг илэрхийлсэн чанарын мэдээлэл зайлшгүй хэрэгтэй. Чанарын судалгааг дараах аргуудаар хийж дүгнэн, үр дүнг нь тооцоолсон.

### *3.2.1. Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлага.*

Сум, дүүргийн Засаг дарга, ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, өрхийн амьжиргааг дэмжих зөвлөлийн нарийн бичгийн дарга, сум, дүүргийн нийгмийн ажилтан, баг хорооны Засаг дарга нартай уулзаж мэдээлэл авлаа.

*Судалгаанд хамрагдсан газрууд:*

1. Өмнөговь аймгийн Булган, Даланзадгад сум,
2. Орхоны Баян-Өндөр, Жаргалант сум,

Source: http://www.undp.mn/reports/

3. Өвөрхангайн Арвайхээр, Зүүн баян-Улаан сум,
4. Улаанбаатар хотын Хан-Уул, Баянзүрх дүүргийн удирдах ажилтнуудыг оролцуулж 12 удаагийн ярилцлагын зохион байгуулсан байна.

**Судалгааны үндсэн асуулгууд**

1. Ядуу хүн гэж хэнийг хэлэх вэ?
2. Хэдэн ядуу өрх байдаг вэ?
3. Нэн ядуу нь хэд байна вэ, хэнийх хамгийн ядуу вэ?
4. Ядуурлыг хэн тодорхойлдог вэ?
5. Ямар аргачлал хэрэглэдэг вэ?
6. Өрхийн орлогын хэмжээг яаж тодорхойлж байна вэ?
7. Ядуу өрхийг ямар шалгуураар тусламж дэмжлэгт хамруулдаг вэ?
8. Ядуу өрхийн хэдэн хувь нь тусламж дэмжлэгт хамрагдсан бэ?
9. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох үндсэн үзүүлэлт нь юу вэ ?
10. Та бүхэн ямар шалгуураар ядуу, нэн ядуу иргэдээ тодорхойлдог вэ?

**Гол мэдээлэгчтэй хийсэн ярилцлагын нэгдсэн дүгнэлт**

Энэ ярилцлаганд оролцсон хүмүүс дараах асуудлуудад санал нэгтэй хандаж байлаа.

1. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутагт ядуурал ихээхэн нэмэгдэж байна. Энэ нь зуд, ган зэрэг байгалийн бэрхшээлтэй холбоотойгоос гадна орон нутагт зах зээл муу хөгжсөн, дэд бүтэц хангалтгүй, ажлын байр нэмэгдүүлэх боломж муу байдагтай холбоотой.
2. Ядуурлын түвшинг тодорхойлох аргачлал хангалтгүй, олон өрх ядууралд хамрагдаж тусламж, дэмжлэг авах сонирхолтой байдгаас ядуу хүний тоог зохиомлоор нэмэгдүүлж байна гэдгийг онцлон тэмдэглэж байв. Өмнөговь аймгийн Булган сумын 5 дугаар багийн Засаг дарга Р.Гомбодорж “Ядуу болохын тулд ах, дүү, хүүхдийнхээ нэр дээр малаа тоолуулсан айл ч мэр сэр гарах болсон” гэдгийг онцлож байв.
3. Ядуу хүмүүст үзүүлэх дэмжлэг хангалттай бус, гурил, будаахан зэргээр хязгаарлагдаж байгаа боловч хөдөөд очих нь бага байдаг гэж ярьж байна. Гэхдээ бэлэн мөнгө, хоол, тусламж өгснөөр ядуу хүмүүсийн амьдрал сайжрахгүй, харин ажлын байр бий болгох талаар анхаарах нь зүйтэй гэсэн саналыг зонхилон дэвшүүлж байлаа.
4. Ядуурал ихтэй сум, аймаг, дүүрэгт тусламж, дэмжлэг өгөөд байвал ядуучуудын тоо улам нэмэгдэх болно. Харин тодорхой ажил хийж иргэдийнхээ амьжиргааг дээшлүүлэх талаар өөрчлөлт хийж байгаа засаг захиргааны нэгжийг дэмжих цаг болсон гэж нилээд хүмүүс үзэж байв
5. Өрхийн орлогын хэмжээг тодорхойлоход хүндрэлтэй байгаа үндсэн шалтгаан нь цалин хөлс, тэтгэвэр, малын орлогоос бусад эх үүсвэрээс орох орлогын хэмжээг бүрэн мэдээлэх систем байхгүйтэй холбоотой гэж ярилцлагад оролцогсод үзэж байв
6. Ядуу иргэдийн тодорхойлохдоо амьжиргааны чадавхи, ажил хийх боломжийг нь харгалзах нь чухал юм. Ажлын чадвартай боловч юу ч хийдэггүй, залхуу хүмүүс ядууд тооцогдох гээд байхад, ажлын чадваргүй, өвчин эмгэгтэй хөгшчүүл тэтгэвэр

авдаг учраас ядуурлаас хасагдах гээд байх юм гэдгийн олон газарт онцлон тэмдэглэж байлаа.

***3.2.2. Сонгосон бүлгийн ярилцлага***

Хүн амын амьжиргааны түвшний талаарх судалгааг үндэслэн баг, хороо тус бүрт 8-10 ядуу, нэн ядуу иргэдээс бүрдсэн 2 бүлэгтэй чиглүүлэх асуултын дагуу ярилцлага хийж, судалгааны үр дүнд тусгасан юм

Судалгаанд дээрх аймаг, сум, дүүрэгт ярилцлагыг 12 удаа зохион байгуулж 100 гаруй хүн оролцсон .

Ярилцлагын чиглүүлэх асуудлууд

1. Ядуу хүн гэж хэнийг хэлэх вэ?
2. Танай баг/сумын хэмжээнд ямар хүнийг ядуу хүнд хамруулж байна вэ?
3. Ямар шалгуураар ядуу хүнийг тодорхойлж байна?
4. Зөв оновчтой тодорхойлж чадаж байна уу?
5. Ядуу хүмүүст зориулсан ямар тусламж дэмжлэг байдаг вэ ? .
6. Энэхүү тусламж, дэмжлэг хүнээ олж өгч чаддаг уу?
7. Өрхийн амьжиргааны түвшинг ямар шалгуураар хэмжих нь зөв вэ?
8. Хэний хэнийх нэн ядууд орох вэ?
9. Эдгээр өрхүүдийг яагаад ядуу гэж бодож байна вэ?

**Ярилцлагын нэгдсэн дүгнэлт.**

Ярилцлаганд ихэвчлэн ядуу, нэн ядуу амьдралтай хүмүүс оролцсон учраас тодорхой саналууд гаргаагүй боловч амьдралд тохиолддог бэрхшээл, ядуурлын шалтгаан, албан тушаалтны үүрэг хариуцлагын талаар өөрсдийн санал бодлыг чөлөөтэй илэрхийлсэн нь аливаа албан ёсны хурал зөвлөлгөөнөөс онцлог байсан гэдгийг онцлон тэмдэглэж байна. Сонгосон бүлгийн ярилцлагаас дараах дүгнэлтийг хийсэн. Үүнд:

1. Ядуу хүмүүсийн тоо их нэмэгдэж байгаа, ялангуяа ядуурлын гүнзгийрэл ихсэж туйлын ядуучууд, үгээгүйчүүд бий болж байна. Гэрийн бүрээс муудаж, өмссөн хувцас урагдлаа, ажил олдохгүй байна гэсэн гомдол их гарах болжээ.
2. Ядуу хүмүүсийг тодорхойлохдоо цалин, тэтгэврийн орлого, өмч хөрөнгө, байр сууцны нөхцлийг харгалзахаас гадна биеийн эрүүл мэнд, харж хандах ах, дүү, нийгмийн эмзэг байдлыг нь харгалзан үзэх нь зөв гэдгийг олон хүн хэлсэн байна. Тухайлвал тэтгэвэр авдаг боловч өндөр настай, өвчин зовлонтой иргэд нэг хүнд ногдох орлогоороо ядууд ордоггүй учраас тусламж, дэмжлэгээс хасагддаг гэнэ.
3. Ядуу иргэдэд олгодог тусламж нь зарим хүмүүсийг өөгшүүлж бэлэнчлэх сэтгэлгээнд сургаж байна. Зарим ядруу биетэй, хөөцөлдөлгөө муутай иргэд ямарч тусламж дэмжлэг авч чадахгүй байна. Ялангуяа хэвтрийн өвчтэй, гэрээс гарч чаддаггүй хүмүүст анхаарах хэрэгтэй гэж байлаа.
4. Ядуу өрхийн амьжиргаа их ойлгомжтой байдаг. Хоол хүнсний зүйлээр гачигдсан, хувцас хунар муутай, гэр орон нь тав тухгүй, үүнээс шалтгаалж эрүүл мэнд нь муудсан хүмүүс л жинхэнэ ядуу амьдралтай байна. Ажил хийдэггүй гэх боловч наймаа худалдаа эрхэлдэг, алт ухдаг, ах дүү нь гадаад болон хот суурин газар амьдардаг олон өрх ядууд тооцогдож улсаас олгох тусламжийг дундлах нь зохимжгүй гэдгийг шүүмжлэн ярьцгааж байлаа.

Source: http://www.undp.mn/reports/

5. Ядуу хүмүүст үзүүлж байгаа тусламж нь ялгавартай, нэн ядуу “өнөө маргаашаа яая” гэж байгаа өрхөд хоол хүнсний зүйл өгч байхад ажилгүй, хөдөлмөрийн чадвартай өрхөд ажил хийх, мөнгө олох боломж олгох нь зүйтэй гэсэн саналыг ярилцлага бүрд илэрхийлж байлаа.
6. Ядуу тарчиг боловч улсаас дэмжлэг авахгүй, өөрсдийн хүчээр амьдарч байгаа өрх, иргэдийг дэмжих нь зүйтэй гэсэн саналыг хэлцгээж байлаа.

### *3.2.3. Ажиглалтын арга*

Чанарын судалгааны нэг хэсэг болох ажиглалтыг баг хороо бүрээс тодорхойлсноор нэн ядуу-3, ядуу-3, ядуу бус–3 айлуудад харьцуулан хийлээ. Ажиглалтыг дараах чиглэлээр мэргэжлийн судлаачдын оролцоотойгоор хийсэн.

**Ажиглалтын үндсэн чиглэл**

1. *Хоол, хүнсний хэрэглээ*: төрөл, давтамж, зарцуулдаг мөнгөний дүн, нөөц,
   - Мах, махан бүтээгдэхүүний хэрэглээ
   - Гурил, гурилан бүтээгдэхүүний хэрэглээ
   - Хүнсний ногооны хэрэглээ
2. *Хувцасны хангамж* : төрөл, чанар, тоо хэмжээ
3. Орон байр, түлшний хангамж: орон сууцны төрөл, тохижилт, ахуй нөхцөл, түлээ, түлшны хангамж
4. *Эд хогш*ил: удаан эдэлгээтэй хөрөнгө, гэрийн тавилга, тээврийн хэрэгсэл
5. Ариун цэврийн барааны хангамж: саван, оо, бусад барааны хэрэглээ

Мөн гэр бүлийн гишүүдтэй ярилцлага хийх замаар өрхийн орлогын хэмжээ, эх үүсвэр, зарлагын бүтцийг баримжаалан судалсан. Судалгааны багийн гишүүн-ажиглагч тухайн өрхийн хэрэглээ, орлого, зарлагын байдлыг үнэлсний дараа тухайн баг, хорооны Засаг дарга нарын дүгнэлт, үнэлгээтэй харьцуулалт хийж тухайн өрх амьжиргааны ямар түвшинд байгаа талаар санал солилцох замаар дүгнэлт хийсэн юм. Ажиглалтын судалгаагаар гарсан дүгнэлт нь нилээд арга зүйн шинжтэй байж болох боловч цаашид анхаарах асуудлын нэг гэж судалгааны багийнхан онцлон тэмдэглэж байна.

**Ажиглалтын судалгааны нэгдсэн дүгнэлт.**

1. Ядуурлын түвшинг зөвхөн нэг үзүүлэлтээр биш хэд хэдэн үзүүлэлтийг хамруулсан хэмжүүрээр нарийвчлан авч үзэх нь амьдралд ойрхон үнэлэлт гарах боломжийг нэмэгдүүлнэ.
2. Амьжиргааны түвшинг тодорхойлохдоо зөвхөн орлогоос гадна хэрэглээ, өрхийн биет ба биет бус хөрөнгийн түвшинг нь авч үзэх нь чухал гэсэн дүгнэлтийг хийхэд хүргэлээ. Чанарын судалгааны явцад мөн өрхөд байгаа тахир дутуу иргэд, байнгын асрамжинд байдаг хэвтрийн өвчтэй хүмүүс өрхийн амьжиргаа, зарлаганд ихээхэн нөлөө үзүүлдэг нь ажиглагдлаа. Мөн өнчин хүүхэд, өндөр настан, архи хэтрүүлэн хэрэглэдэг хүмүүс, өрх толгойлсон олон хүүхэдтэй эхчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгийнхнийг тусгайлан онцлон үзэх шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийлээ.

Source : http://www.ulcp.mn/reports/

***3.2.4. Санал асуулгын арга***

Тоон судалгааны үндсэн дээр бий болсон өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох хэмжүүрүүдийг бататгах, иргэдийн санал бодлыг сонсох, ядуурлын талаар иргэдийн санал бодолд тандалт хийх, ядууралд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодотгох зэрэг олон агуулга, зорилготойгоор жижиг хэмжээний социологийн санал асуулгыг бэлтгэн санамсаргүй, түүвэр судалгаа хийж судалгааны бусад үр дүнтэй уялдуулах ажлыг хийлээ. Гэхдээ сонгосон аймаг, сум, дүүрэг, хорооноос санамсаргүй түүврээр аймгийн төвийн сумаас 100, хөдөөгийн сум бүрээс 50-иас доошгүй хүнээс мэдээлэл цуглуулж дүгнэлт хийлээ. /хавсралт 1/ Санал асуулгын хуудас/ Санал асуулганд 650 хүн оролцсон бөгөөд 66,7 хувь нь хотод, 33,3 хувь нь хөдөөд амьдардаг, 35,5% дээд боловсролтой, 48,38 хувь нь бага, бүрэн ба бүрэн бус дунд, эсвэл боловсролгүй хүмүүс, 41,7 хувь нь эрэгтэй, 58,3 хувь нь эмэгтэйчүүд байлаа.

**Санал асуулгын нэгдсэн дүгнэлт.**

Санал асуулгын дүнгээс дараах нэгдсэн дүгнэлтийг хийж болох юм. /Хавсралт 2/

1. Сүүлийн 4 жилд Монгол улсад ядуурал нэмэгдсэн гэж судалгаанд оролцогсдын 55,6 хувь нь үзсэн байхад 23,8 хувь нь ядуурлын түвшин хэвэндээ байгаа гэж дүгнэжээ. Цөөнгүй тооны оролцогчид энэ асуултыг хариулж “мэдэхгүй “ гэсэн байна.
2. Өнөөдөр хүмүүсийн гачигдаж дутагдаж байгаа зүйлийн талаар тодруулсан асуултад судалгаанд оролцогчдын 38.5 хувь мөнгөөр, 27,8 хувь мэдлэг боловсролоор дутагдаж байна гэж хариулсан нь хамгийн өндөр хувийн жин эзэлж байна. Ялангуяа хөдөө орон нутгийн оролцогчдын ихэнх хэсэг нь мөнгөнөөс гадна ажлын байр олддоггүй гэсэн хариултыг тэмдэглэсэн байна. Түүнчлэн орон байрын асуудал ихээхэн хүндрэлтэй байгааг судалгаараар тодорхойлжээ. Харин ядуу амьдралтай гэж өөрсдийгээ тодорхойлсон өрхийн гишүүд хоол, хүнс, хувцас зэрэг анхдагч хэрэглээний зүйлээр гачигдаж байдаг гэсэн нь судалгааны анхаарал татсан асуудлуудын нэг гэж онцлон тэмдэглэж байна.
3. Өрхийн амьжиргааг тодорхойлох үндсэн үзүүлэлтэд ямар үзүүлэлтүүд хамрагдаж болох вэ гэсэн асуултад судалгаанд хамрагдсдын 82,6 хувь нь орлого, 66,5 хувь нь ажил эрхлэлт, 46,6 хувь нь орон байрны нөхцөл, 35,7 хувь нь мэргэжил боловсрол, 27,8 хувь нь эрүүл мэнд гэж хариулсныг аргачлал боловсруулахад харгалзан үзсэн болно.
4. “Ядуу хүн гэж хэнийг хэлэх вэ?” гэсэн асуултад орон гэрээр зутруу, байнгын орлогогүй, хувцас хунар муутай хүмүүсийг хэлнэ гэж 63 хувь нь тэмдэглэсэн байна. Харин “Үгээгүй ядуу хүн гэж хэнийг хэлэх вэ?” гэсэн асуултанд асуулганд оролцогчдын 40 орчим хувь нь “залхуу, арчаагүй хүнийг хэлнэ” гэсэн нь анхаарал их татаж байна. Энэ нь ядуурлыг нийгмийн хүчин зүйл гэж үзэх шалтгаан Монголд бага байдаг гэсэн үзэл бодол давамгайлж байдагтай холбоотой байж болох юм. Харин дээрх асуултад 50 хувь нь “хоол, хүнсээр, гачигдсан, солих хувцасгүй, орон гэрийн нөхцөл муу хүнийг хэлнэ” гэж хариулсан байна.
5. Орон сууцны нөхцлийн асуултанд 82 хувь нь өөрийн гэр буюу байртай гэсэн бол 4.7 хувь нь орон гэргүй гэжээ. Мөн айлын гэрт амьдардаг хүн 13 хувийг эзлэж байна.
6. Иргэдийн амьжиргааг тодорхойлж байгаа өнөөгийн аргачлалын үр дүнгийн талаарх асуултад 44.7 хувь нь үнэн зөв үнэлж чадахгүй байна гэсэн нь баг, хороонд өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох аргачлал хангалтгүй байгааг харуулж байна.
7. Асуулгад оролцогчдын 49.9 хувь нь “боломжийн” амьдарч байна гэсэн байхад 30

хувь нь амьжиргааны чадавхи дорой гэсэн байна. Харин 18.7 хувь нь ядуу, 1.8 хувь нь "Үгээгүй" амьдралтай гэж өөрсдийгөө үнэлжээ.

## 3.3 Өрхийн амьжиргааны түвшингийн түүвэр судалгаа ( мэдээ цуглуулалт, боловсруулалт, үр дүн)

Өрх, иргэдийн амжиргааны түвшинг тодорхойлох хэмжүүрийг нарийвчлан гаргаж авахын тулд тоон болон чанарын судалгаагаар тодорхойлогдсон үр дүнг үндэслээд сонгож авсан аймаг, дүүргийн зарим өрхүүдийн амьжиргааны түвшинд түүвэр судалгааг хийж гүйцэтгэсэн.

***Үндсэн зорилго*:** Өрх, иргэдийн амьжиргааны түвшингийн шалгуур үзүүлэлт, хэмжүүрүүдийг тодорхойлох

***Хамарсан хүрээ*:** Өмнөговь, Өвөрхангай, Орхон аймгийн 6 сум, нийслэлийн Хан-Уул, Баянгол дүүргийн 4 хорооны 450 өрх хамрагдсан.

***Хугацаа:*** 2004 оны10-12 сар

***Түүвэрлэлтийн сонголт*:** Нэн ядуу, ядуу , ядуу бус өрх

***Судалгааны үндсэн үзүүлэлт*:** 125 сонголт бүхий 21 үзүүлэлтээр асуулга боловсрогдсон /Хавсралт 3/. Асуулгыг бөглөх заавар /Хавсралт 4/-ыг нарийвчлан гаргаж судалгаа авах багийн гишүүдэд сургалт зохион байгуулсан.

Судалгааны үндсэн үзүүлэлтүүд:

1. Суурьшил
2. Өрхийн амьжиргааны түвшин: баг, хорооноос орлогын хэмжээг үндэслэн тодорхойлж байгаа аргачлалаар.
3. Өрхийн амьжиргааны түвшин: оролцооны аргаар
4. Өрхийн нэг гишүүнд ногдох тогтоосон орлого
5. Өрхийн ам бүлийн тоо
6. Өрхийн гишүүдийн нас, хүйс
7. Хөдөлмөр эрхлэлт
8. Эрүүл мэнд, эмзэг байдал
9. Боловсрол
10. Өрхийн орлого
11. Малын тоо
12. Газар тариалан
13. Сууцны байдал
14. Цахилгаан хангамж, халаалт
15. Усан хангамж, сувагжуулалт
16. Удаан эдэлгээтэй хөрөнгө, хадгаламж
17. Хүнсний хэрэглээ
18. Хүнсний бус зарим хэрэглээ /хувцас, эрүүл мэнд, боловсролын г.м/
19. Нийгмийн халамжид хамрагдалт, тусламж, дэмжлэг авалт
20. Татвар, даатгал төлөлт
21. Сургуульд хамрагдалт зэрэг болно.

Эдгээр үзүүлэлтүүдийг сонгохдоо олон улсын арга аргачлал, манай оронд өмнө хийгдсэн

Source : http://www.undp.mn/reports/

судалгаагаар өрхийн амьжиргаанд нөлөөлөх гол үзүүлэлт болох нь батлагдсан байдал, судалгааны багаас явуулсан санал асуулгаар олонхийн санал авсан байдал /тайлангийн 2, 3дахь хэсэг/ зэргээс үүдэн сонгосон юм. Тухайлбал, эдгээрээс суурьшил, ам бүлийн тоо, сууцны байдал, мал аж ахуй, газар тариалан эрхлэлт, ажил хөдөлмөр эрхлэлт, дэд бүтцийн хангамж, удаан эдэлгээтэй хөрөнгө, хадгаламж, сургуульд хамрагдалт зэрэг үзүүлэлтүүд 1998, 2002-2003 онд хийгдсэн Өрхийн амьжиргааны түвшний судалгаа, жил тутам хийгддэг Өрхийн орлого зарлагын судалгаанд /зарим нь/ хэрэглэгдсэн байлаа. Тэрчлэн аль болох олон үзүүлэлтээр мэдээлэл цуглуулаад тэднээсээ хамгийн тохиромжтой үзүүлэлтүүдийг сонгож авах зарчим баримталсан. /Хавсралт 5,6/

Өрх, иргэдийн амьжиргааны түвшингийн түүвэр судалгаа нь ядуу, нэн ядуу эрхийн тоог тодорхойлоход биш, тэдний амьдралыг чадавхийг илэрхийлэх шалгуур, хэмжүүрүүдийг сонгон авахад чиглэгдэж байлаа. Иймээс судалгаа авагдсан 21 үзүүлэлт 125 сонголтоос дараах шалгууруудыг онцлон анхаарах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийсэн юм. Үүнд:

1. Өрхийн ам бүлийн тоо нь амьжиргаанд ихээхэн нөлөөлдөг нь тогтоогдлоо. Ам бүл цөөн буюу 4 хүртэл гишүүнтэй өрх ядуурал өртөх нь бага, тэдний 25-42 хувь нь амьжиргааны түвшингээс доош орлоготой амь зуудаг гэсэн дүгнэлт гарчээ. Харин 6-гаас дээш ам бүлтэй өрхийн 85 орчим хувь нь ядуу амьдралтай байгааг нь судалгаагаар тогтоогдлоо.
2. Боловсролын түвшин өрхийн ядуурал урвуу хамааралтай гэсэн дүгнэлт гарсан юм. Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин өндөр байх тусам амьжиргаа нь дээшилж ядуурал түүртэхээ больдог байна. Бүрэн дундаас доош боловсролтой өрхийн 80-иас дээш хувь нь ядуу амьдарч байхад дээд боловсролтой өрхийн дөнгөж 20 хувь нь ядуурал өртөх эрсдэл ямар нэгэн хэмжээнд байгааг судалгааны дүнгээс харж болох юм.
3. Өрхийн орлогын үндсэн эх үүсвэрийг бүрдүүлэгч ажил эрхлэлтийн байдал амьжиргаанд шууд нөлөөлж байна. Олон улсын байгууллага, төрийн өмчийн үйлдвэрт ажиллагчдын гэр бүлийн амьжиргааны түвшин харьцангуй өндөр байдаг ажээ. Харин ажилгүй, түр, улирлын чанартай ажил үүрэг гүйцэтгэгчийн 80 гаруй хувь нь ядуу амьдаралтай гэсэн дүн судалгаагаар гарчээ.
4. Сууцны нөхцөл нь амьжиргааны түвшинг тодорхойлох нэг үзүүлэлт гэж олон оронд хэрэглэдэг. Манай улсын хувьд дулаан, цахилгаан, усан хангамж бүхий тохилог сууцанд амьдрагчдын амьжиргааны түвшин харьцангуй сайн, тэдний дөнгөж 4 хувь нь ядуу амьдралтайд тооцогдож байна. Харин нийтийн байр, зориулалтын бус өрөө, орц, хонгилд амьдрагчдын 60-иас дээш хувь нь ядуу, нэн ядуу амьдралтай ажээ.
5. Хөрөнгө мөнгөний бололцоотой, мөнгөн хуримтлал ямар нэгэн хэмжээнд хийсэн бол өрхийн амьжиргаа нь гайгүй байгааг харуулах үзүүлэлт болдог байна. Судалгаанд хамрагдсан мөнгөн хадгаламжтай гэсэн өрхүүдийн амьжиргааны түвшин ядуурлын шугамаас өндөр байна. Харин мөнгө хадгалж чадаагүй өрхийн 40 гаруй хувь нь ядуурал өртөх магадлалтай байгааг судалгааны дүн харуулж байна.
6. Өрхийн орлого олдог гишүүдийн тоо амьжиргааг тодорхойлох нэг хэмжүүр болж болох юм. 2-оос дээш гишүүн нь байнгын орлоготой өрх ядуурал өртөх магадлал маш бага байна. Гэхдээ тухайн хүний орлогын хэмжээ нь нөлөөлж болохыг 3 хүн орлоготой өрхийн 7.7 хувь нь ядуу байхад 4 хүн нь орлоготой өрхийн 28.6 хувь нь ядуу амьдарч байгаа гэж судалгааны дүн харуулж байна. Иймд орлогын хэмжээг нарийвчлан зааж өгөх хэрэгтэй байна.

7. Тээврийн хэрэгслийг амьжиргааг илэрхийлэх нэг шалгуур болгож олон оронд хэрэглэдэг. Манай орны нөхцөлд тээврийн хэрэгсэлийн төрлөөр амьжиргаа нь ялгаатай байж болохыг судалгааны дүн харуулж байна. Автомашинтай өрхийн 4 хувь нь ядуу байхад мотоцикльтэй өрхийн 38,4 %, тракторто й өрхийн 50 хувь нь ядуу байна.

8. Түүвэр судалгааны асуулганд хүнсний хэрэглээ, хувцасны хангамжны асуудал орсон боловч магадлах, шалгах боломж муутай, үнэн зөв мэдээлэл авахад бэрхшээлтэй байсан гэдгийг онцлон тэмэлэглэж байна.

9. Түүвэр судалгаагаар өрхөд байгаа эмзэг бүлгийн хүмүүс нь арчилгаа, халамж их шаарддаг, нэмэгдэл хөрөнгө, мөнгийг эм тарианд гэх мэтэд их зарцуулдаг гээд өрхөд энгийн айлуудаас их дарамт, зардал учруулдаг нь тогтоогдлоо. Энэ үзүүлэлтийг ч гэсэн өрхийн чадавхийг тодорхойлохдоо анхаарах нь зүйтэй гэсэн санааг дэвшүүлж байна.

10. Сум, багийн түвшинд ядуу өрх, иргэдийг тодорхойлж байгаа арга, аргачлал нь амьдралд төдийлөн таарахгүй, орлогын хэмжээг бүрэн тусгаж чадахгүй байна гэсэн дүгнэлтийг хийхэд хүрсэн байна. Ялангуяа хот, суурин газарт өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлохдоо хүсэлт гаргагчийн хэлсэн орлогын хэмжээ, ам бүлийн тоо зэргийг харгалздаг нь шаардлага хангахгүй олон хүн ядууд тооцогдож, тусламж, дэмжлэг авах сонирхлыг нэмэгдүүлж байдаг ажээ.

Source : http://www.undp.mn/reports

# 4 ӨРХИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛГЭЭ, ТООЦООЛОЛ

Өмнөх бүлэгт хийгдсэн тоон болон чанарын судалгааны дүн, хөгжлийн ижил төстэй орнуудад хэрэглэж байгаа өрх, иргэдийн амьжиргааны түвшинг орлогын бус аргаар тодорхойлох арга, аргачлал, судалгааны багаас хийсэн өрхийн амьжиргааны түвшингийн түүвэр судалгаагаар нарийвчлан боловсрогдсон хэмжүүр, шалгууруудыг үндэслэж Монгол орны онцлогт тохирсон, энэхүү төслийн зорилгонд нийцсэн арга, аргачлалыг боловсруулах талаар дараах ажлууд хийгдлээ.

## 4.1 Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлтүүд

Бид өрхийн амьжиргааны түвшинг орлого ба зарлагын хэмжээгээр бус амьжиргааны чадавхийг илэрхийлж чадахуйц орлуулах хэмжүүрүүдээр тодорхойлох шинэ аргачлалыг дэвшүүлж байна. Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг энэхүү шинэ, хялбаршуулсан аргаар тодорхойлоход нэн тэргүүнд хүн амын амьжиргааны түвшинг тодорхойлж чадахуйц үзүүлэлтүүдийг сонгож авах нь чухал ач холбогдолтой байв.

***Үзүүлэлтийн сонголтын шалгуур:*** Бид өрхүүдэд түүвэр судалгаа явуулсан 21 үзүүлэлтээсээ өрх иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалд оруулах үзүүлэлтийг сонгохдоо дараах шалгууруудыг баримтлсан юм. Үүнд:

1. Тухайн үзүүлэлт нь өрх, иргэдийн амьжиргааны түвшинд нөлөөлж байгаа нь судалгаагаар батлагдсан байх;
2. Энэ үзүүлэлтийг тооцоход өртөг зардал, цаг хугацаа бага шаардах байдал;
3. Үнэлэх, дүгнэх, хянах бололцоотой, хялбар байх;
4. Үнэлгээний үр дүн нь иргэдэд ойлгомжтой, бодитой байх;
5. Хөгжлийн ижил төстэй орнуудын амьжиргааг тодорхойлох аргачлалд хэрэглэгддэг туршлага зэрэг болно.

***Сонгон авсан үзүүлэлтүүд:*** Шинэ аргачлалд дор дурдсан 11 үзүүлэлт 70 гаруй хэмжүүрийг өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлоход ашиглахаар сонгон авсан. Үүнд:

**I. Өрхийн амьжиргааны чадавхийг илэрхийлэх үзүүлэлтүүд:**

1. Өрхийн суурьшилт, орон зайн алсалт(4 хэмжүүр )
2. Өрхийн ам бүлийн тоо(8 хэмжүүр )
3. Өрхийн боловсролын түвшин (7 хэмжүүр )

Source: http://www.undp.mn/reports/

4. Өрхийн хөдөлмөр эрхлэлтийн байдал(14 хэмжүүр )
5. Өрхийн орон сууцны нөхцөл (7 хэмжүүр )

**II. Өрхийн эдийн засгийн чадавхийн үзүүлэлтүүд:**

6. Хөрөнгө (6 хэмжүүр )
7. Өрхийн орлого олдог гишүүдийн тоо (4 хэмжүүр )
8. Тээврийн хэрэгсэл (5 хэмжүүр )
9. Тусламж, дэмжлэг( 5 хэмжүүр)

**III. Нийгмийн эмзэг байдлын үзүүлэлтүүд:**

10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд (6 хэмжүүр )
11. Өрхийн нийгмийн эмзэг байдал (5 хэмжүүр )зэрэг болно.

Харин дээрх судалгаанд хамрагдсан үзүүлэлтүүдээс орлогын хэмжээ, хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний хэрэглээ, татвар, даатгал төлөлт, дэд бүтцийн үзүүлэлтүүд зэрэг олон үзүүлэлтүүд өрх, иргэдийн амьжиргааны түвшинд шууд нөлөөлж болох боловч тооцоолоход хүндрэлтэй, өртөг зардал, ажиллагаа их шаарддаг, хянах, нягтлах боломж муу зэргээс шалтгаалан энэ удаагийн аргачлалд хамруулсангүй.

## 4.2 Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлтүүдийн үнэлгээний аргачлал

Сонгож авсан үзүүлэлтүүддээ үнэлгээ өгөхийн тулд олон улсын хэмжээнд өрхийн амьжиргаа, ядуурлыг хэмждэг олон арга ялангуяа манай орны нөхцөлд авч хэрэглэж болох, бидний судалгааны зорилгод нийцэх аргуудыг онцлон судалсан юм. Ядуурлын түвшинг тогтоох янз бүрийн аргууд байдаг бөгөөд эдгээр нь үндэсний хэмжээнд, бүс нутгийн хэмжээнд, өрхийн түвшинд ядуурлыг хэмжих чиглэлүүдээр ялгаатай байдаг байна. Бид судалгааны зорилгод нийцүүлэн өрх гэрийн түвшинд ядуурлыг хэмжих аргуудад голлон анхаарснаар өрхийн ядуурлыг тодорхойлох “тэнцвэржих цэг” (Wolf Point or equilibrium point method)[5]-ийн аргыг сонгон авсан юм. Энэ аргаар ядуурлын шугмыг өрхийн орлого, зардалтайгаа тэнцэж, хадгаламж тэгтэй тэнцэх орлогын хэмжээгээр тодорхойлдог. Судалгааны баг орлогын бус хэмжигдэхүүнээр өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох зорилготой учраас энэ аргыг хэрэглэхдээ орлого, зарлага бус хүн амын хувийн жин, ядуурлын хувийн жин гэсэн үзүүлэлтүүдийг сонгон авч, “Ядуурлад өртөх эрсдлийн коэффициент” гэсэн үнэлгээний хэмжүүрийг ашигласан онцлогтой. “Ядууралд өртөх эрсдлийн коэффициент” /Кэ/ нь тухайн үзүүлэлтээр илэрхийлэгдэх ядуу хүн амын хувийн жин, энэ бүлгийн хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувийн жингийн харьцаагаар дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$K_{э} = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right)$$

$K_{э}$ - ядууралд өртөх эрсдлийн коэффициент

$P_{ях}$ - Тухайн бүлгийн ядуу хүний нийт ядуучуудад эзлэх хувийн жин

$Рун$ - Тухайн бүлгийн хүн амын улсын нийт хүн амд эзлэх хувийн жин

Хүн амын болон ядуучуудын хувийн жинг дараах томъёогоор илэрхийлж болно.

---

[5] *Julio Boltvinik “Poverty Measurement Methods- An Overview” page 11, http://www.undp.org./poverty/publications/*

$$P_{\text{УН}} = \frac{T_{\text{БХ}}}{T_{\text{УХ}}} \qquad\qquad P_{\text{ЯХ}} = \frac{T_{\text{БЯ}}}{T_{\text{УЯ}}}$$

$T_{\text{БХ}}$ – тухайн бүлгийн хүн амын тоо

$T_{\text{УХ}}$ - улсын нийт хүн амын тоо

$T_{\text{БЯ}}$ - тухайн бүлгийн ядуу хүний тоо

$T_{\text{УЯ}}$ - улсын хэмжээний нийт ядуу хүний тоо

Энэ коэффицент (Кэ) нь тухайн өрхийн ядуурлад орох эрсдлийг харуулах бөгөөд эерэг, сөрөг утга авч эерэг тоо гарвал ядуурлын шугамаас холдох, сөрөг тоо гарвал ядуурлад өртөх эрсдэл нэмэгдэхийг харуулна.

Эрсдлийн коэффицентыг үндэслэж сонгон авсан үзүүлэлт бүрээр өрхийн амьжиргааны түвшинг үнэлнэ. Энэ үнэлгээг хийхдээ “тэнцвэржих цэг” болох 1-ээс эрсдлийн коэффицентыг хасаж тодорхойлно. Тухайн үзүүлэлтээр тодорхойлогдох үнэлгээ нь “тэнцвэржих цэг” болох 1-тэй тэнцүү бол ядуурлын шугам дээр байгааг, 1-ээс их бол ядуурлад өртөх эрсдэл их байгааг, 1-ээс бага бол ядуурлад өртөх эрсдэл буурахыг тодорхойлох юм. Үүнийг дараах томъёогоор илэрхийлж болно.

$$\text{Ү}_n = 1 - \left( \frac{P_{\text{УН}} - P_{\text{ЯХ}}}{P_{\text{УН}}} \right)$$

$\text{Ү}_n$ - Тухайн үзүүлэлтээс хамаарах амьжиргааны үнэлгээ

Амьжиргааны үнэлгээ “тэнцвэржих цэг” болох 1- ээс их байвал ядуу, бага байвал ядуу бус болно. Олон улсын шинжээч Лидиа Барреирас /Lidia Barreiras/ тэнцвэржих цэгийн энэ арга ядуурлын шинжилгээний үндсэн зарчим болох ёстой”[6] гэж 1992 онд тэмдэглэсэн тухай дээр өгүүлсэн билээ.

Ядууралд өртөх эрслийн коэффицент (Кэ) болон амьжиргааны үнэлгээ (Үn) нь сонгож авсан 11 үзүүлэлт бүрээр тодорхойлогдох бөгөөд үзүүлэлт бүрээр тодорхойлогдсон үнэлгээний арифметик дунджаар өрх, иргэдийн амьжиргааны түвшингийн үнэлгээ (АТҮ) илэрхийлэгдэнэ.

$$AT\ \text{Ү} = \frac{(\text{Ү}_1 + \text{Ү}_2 + \text{Ү}_3 + \dots + \text{Ү}_{11})}{11}$$

Амьжиргааны түвшинг тодорхойлохоор сонгож авсан 11 үзүүлэлт бүрээр эрсдлийн коэффицент болон амьжиргааны үнэлгээг дээрх аргачлалаар нэг бүрчлэн тооцож тогтооно. Тухайлвал: суурьшилтанд Улаанбаатар, аймгийн төв, сумын төв, хөдөө гэсэн 4 хэмжүүр ашиглагдаж байхад ам бүлийн тоо гэсэн үзүүлэлтэд 8, хөдөлмөр эрхлэлтэнд 14 хэмжүүр ашиглагдаж байна. (Хавсралт 8, 9)

Source : http://www.undp.mn/reports/

---

[6] *Jolio Boltvinik “Poverty Measurement Methods- An Overview” page -12, http://www.undp.org./poverty/publications/*

Эдгээр хэмжүүрээр тухайн өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлохдоо өрхийн тэргүүн эсвэл түүний төлөөлөгч нь өөрийн өрхийн амьжиргааны талаар эхний мэдээллийг өгөх бөгөөд үнэн зөв, бодит байдалд нийцэж байгаа эсэхийг нь баг, хорооны эрх бүхий албан тушаалтангууд (баг, хорооны засаг дарга, нийгмийн ажилтан, зохион байгуулагч гэх мэт) баталгаажуулна. (Хавсралт 7)

Амьжиргааны түвшингийн үнэлгээ (АТҮ) ихэсэх тусам ядууралд орж байгааг харуулна. Өөрөөр хэлвэл АТҮ > 1.0 бол ядуу,

АТҮ < 1.0 бол ядуу бус болно.

Энэ үнэлгээг үндэслээд өрхийн иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлохдоо дараах интервалийг баримтална.

Өрх, иргэдийн амьжиргааны түвшингийн шатлал:

| Амьжиргааны түвшин | АТҮ |
|---|---|
| 1. Чинээлэг | 0,650-аас бага |
| 2. Боломжийн | 0,651-0,800 |
| 3. Дундаж | 0,801-0,950 |
| 4. Ядуу | 0.951-1,115 |
| 5. Нэн ядуу / Үгээгүй/ | 1,115-аас дээш |

## 4.3 Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлтүүдийн нөлөөлөл, үнэлгээ, тооцоолол

Өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлохоор сонгон авсан үзүүлэлтүүдийн үнэлгээний тооцооллыг дээр дурдсан аргачлалаар суурьшилт, ам бүлийн тоо, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, орон сууцны нөхцөл зэрэг амьжиргааны чадавхийг илэрхийлэх үндсэн үзүүлэлтүүдээр тооцож үзье.

### *4.3.1. Амьжиргааны түвшинд суурьшилтын үзүүлэх нөлөөлөл ба үнэлгээ*

Хүн амын оршин суугаа газар нь тэдний амьжиргааны түвшинд тодорхой нөлөөлөл үзүүлдэг нь судлагаанаар гарсан. Хот, хөдөөгийн хүний хөгжлийн ялгаатай байдал нь өрхийн амьжиргааг тодорхойлоход чухал нөлөө үзүүлж байна гэсэн Монголын хүний хөгжлийн илтгэл 2003–ын дүгнэлт ч энэ таамагналыг батлаж байгаа юм. Харин суурьшилт өрх иргэдийн амьдралд ямар нөлөө үзүүлж, хир хэмжээгээр нөлөөлж байгааг энэ хэсэгт тодруулан авч үзье.

**а. Суурьшилтын өрх, иргэдийн амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл**

Судалгаанд хамрагсдын байдлаас харахад сумын төв, хөдөөд ажилгүйдэл, хагас ажилгүйдэл ихтэй, бэлэн мөнгөний орлого багатай, зах зээлээс алслагдсан зэргээс шалтгаалан амьжиргааны түвшин доогуур байна. Энэ дүгнэлтийг ҮСГ-аас хийсэн Өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшины түүвэр судалгаа (ӨОЗАТТС 2002/03)-ны дүнгээр давхар батлаж болно.

ӨОЗАТТС-ны дүнгээс үзэхэд нийт хүн амын 36.1 хувь нь ядуурлын шугамаас доогуур орлоготой байхад хотын хүн амын 27.3 хувь, аймгийн төвийн хүн амын 33,9 хувь, сумын төвд амьдрагчдын 44.5 хувь, хөдөөд амьдрагчдын 42.7 хувь нь ядуурлын шугмаас доогуур орлоготой аж төрдөг ажээ. Энэ нь сумын төвийн хүн амын ядуурлын түвшин хотынхоос даруй 17.2 пунктээр, улсын дундажаас 8.4 пунктээр өндөр байна гэсэн үг.

*График 4-1*

**Хот, хөдөөгийн ядуурлын түвшиний харьцуулалт**




*Эх сурвалж: ӨОЗАТТС 2002/03*

Нөгөө нэг хэмжүүр ядуучуудын эзлэх хувийн жингээр нь авч үзвэл нийт хүн амын 16.2 хувь нь сумын төвд амьдарч байхад, нийт ядуу иргэдийн 20.0 хувь нь сумын төвд амьдардаг судалгаа гарлаа. Энэ нь сумын төвд амьдрагчдын ядуурал өртөх нь харьцангуй өндөр байна гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл хотын 10 хүний 3 нь ядуурал өртөж байхад сумын төвийн 10 хүний 5 ядуу амьдарч байна. Шалтгаан нь хөдөөгийн хүн ам ган, зуд, байгалийн хүчин зүйлийн нөлөөлөлд өртөх нь их, орлого олох боломж нь харьцангуй бага байдгаар тайлбарлагдана. Харин Улаанбаатарт нийт хүн амын 30.2 хувь нь амьдардаг боловч нийт ядуучуудын 22.8 хувь нь амьдарч байгаа нь хотын иргэд өөрсдийн санаачлага, идэвхи зүтгэлээ дайчилвал ядуурлаас гарах, ажил хийх, орлого олох боломж хөдөөгийнхнөөс их гэдгийг харуулж байна.

**б. Суурьшилтын нөлөөллийн үнэлгээ**

Монгол орны онцлогыг үндэслэж өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох нэг хэмжүүрт иргэдийн амьдарч байгаа газрыг хот, аймгийн төв, сумын төв, хөдөө гэсэн 4 ангиллаар хамруулах саналыг үндэслэж үнэлгээг өмнөх хэсэгт дурдсан аргачлалаар дараах байдлаар тодорхойлж болно. Үүний тулд Улаанбаатар, аймаг, сумын төв, хөдөөгийн ядуучуудын улсын хэмжээний нийт ядуучуудын тоонд эзлэх хувийн жинг, тухайн нутаг дэвсгэрийн хүн амын улсын нийт хүн амд эзлэх хувийн жинд харьцуулах замаар ядуурал өртөх эрсдлийн коэффициент /$К_э$/-ийг гарган, суурьшлын орон зай тус бүрийн амьжиргааны үнэлгээг гаргана. Тухайлвал:

**Улаанбаатарт:**

$$K_э = \left(\frac{P_{УБХ} - P_{УБЯ}}{P_{УБХ}}\right) = \left(\frac{30{,}2 - 22{,}8}{30{,}2}\right) = 0{,}245$$

$$Y_{1(УБ)} = 1 - \left(\frac{P_{убх} - P_{убя}}{P_{убх}}\right) = \left(\frac{30{,}2 - 22{,}8}{30{,}2}\right) = 0{,}755$$

$P_{\text{УБя}}$ - Улаанбаатарын ядуу хүний нийт ядуучуудад эзлэх хувийн жин

$P_{\text{УБх}}$ - Улаанбаатарын хүн амын улсын нийт хүн амд эзлэх хувийн жин

Улаанбаатарчууд ядуурвалд өртөх нь харьцангуй бага буюу ядуурлын шугам/1.0/-аас 0.245 пункт зайтай байна. Харин Улаанбаатарынхны суурьшилтаас хамаарах амьжиргааны үнэлгээ нь 0.755 болж байна.

**Аймгийн төвд**:

$$K_{\text{э}} = \left(\frac{P_{\text{ах}} - P_{\text{ая}}}{P_{\text{ах}}}\right) = \left(\frac{25{,}2 - 23{,}7}{25{,}3}\right) = 0{,}059$$

$$\text{Y}_{1(AT)} = 1 - \left(\frac{P_{\text{ах}} - P_{\text{ая}}}{P_{\text{ах}}}\right) = 1 - \left(\frac{25{,}2 - 23{,}7}{25{,}3}\right) = 0{,}941$$

Аймгийн төвийнхний ядуурвалд өртөх эрсдэл нилээд өндөр, суурьшилтаас хамаарах амьжиргааны үнэлгээ нь ядуурлын шугам буюу 1-д маш ойрхон гарч байна.

**Сумын төвд**:

$$K_{\text{э}} = \left(\frac{P_{\text{сх}} - P_{\text{ся}}}{P_{\text{сх}}}\right) = \left(\frac{16{,}2 - 20{,}0}{16{,}2}\right) = -0{,}235$$

$$\text{Y}_{1(C)} = 1 - \left(\frac{P_{\text{сх}} - P_{\text{ся}}}{P_{\text{сх}}}\right) = 1 - \left(\frac{16{,}2 - 20{,}0}{16{,}2}\right) = 1{,}235$$

Сумын төвд оршин суугчдын ядуурвалд өртөх эрсдлийн коэффицент -0,235 гарч байгаа нь энд амьдрагчид ядуурвалд өртөх эрсдэл ихтэй, суурьшилтаас хамаарах амьжиргааны үнэлгээ нь ядуурлын шугамаас хэтэрч 1.235 болсон нь сумын төв гэсэн суурьшлын орон зайн амьжиргааны түвшинд үзүүлэх сөрөг нөлөө өндөр байгааг харуулж байна. Сумын төвд амьдрагчдын амьжиргааны түвшин доройтох эрсдэл Улаанбаатраас 40 орчим пунктээр өндөр байна.

**Хөдөөд:**

$$K_{\text{э}} = \left(\frac{P_{\text{хх}} - P_{\text{хя}}}{P_{\text{хх}}}\right) = \left(\frac{28{,}4 - 33{,}6}{28{,}4}\right) = -0{,}183$$

$$\text{Y}_{1(X)} = 1 - \left(\frac{P_{\text{хх}} - P_{\text{хя}}}{P_{\text{хх}}}\right) = 1 - \left(\frac{28{,}4 - 33{,}6}{28{,}4}\right) = 1{,}183$$

Энд амьдрагчдын ядуурвалд өртөх эрсдлийн коэффицент -0,183 гарч байгаа нь ядуурвалд өртөх эрсдэл ихтэй байгаа боловч сумын төвд амьдрагчдаас арай бага байна гэсэн үг юм. Хөдөө амьдрагчдын суурьшилт, орон зайнаас хамаарах амьжиргааны үнэлгээ ядуурлын шугмаас хэтэрсэн тооцоо гарч байна.

Өрх, иргэдийн амьжиргааны түвшингийн үнэлгээ нь ядууралтай ямар хамааралтай болохыг шалгах зорилгоор ядуурлын хамрах хүрээ, амьжиргааны үнэлгээ 2-ын харьцуулалтыг гаргаж үзлээ. График 4-2

Source: http://www.undp.mn/

*График 4-2*

**Ядуурлын хамрах хүрээ ба эрсдлийн харьцуулалт**




Дээрх харьцуулалтаас дүгнэлт хийхэд ядуурлын хамрах хүрээ өндөр газар амьжиргааны үнэлгээ өндөр байгаа нь харагдаж байна. Энэ нь бидний дэвшүүлж байгаа ядуу иргэдийн тоо, ядуурaлд өртөх эрсдлийн коэффициент, амьжиргааны үнэлгээний хамаарлын үндэслэл бодитой, үнэлгээний аргачлал нь боломжийн болохыг харуулж байна.

*График 4-3*

**Өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ**
**( суурьшлын хамаарлаас)**




*Эх сурвалж: ӨОЗАТС 2002/03*

***4.3.2. Амьжиргааны түвшинд ам бүлийн тооны үзүүлэх нөлөөлөл ба үнэлгээ***

Тоон ба чанарын судалгаагаар өрхийн ам бүлийн тоо амьжиргааны түвшинг тодорхойлох үзүүлэлтүүдийн нэг болж байгааг гаргасан. Энэ үзүүлэлт өрх иргэдийн амьжиргаанд ямар нөлөө үзүүлж байгаа, түүнийг хэрхэн үнэлсэн аргачлалыг тодруулан авч үзье.

**а. Өрхийн амьжиргаанд ам бүлийн тооны нөлөөлөл .**

Судалгааны дүнгээс үзэхэд 3 хүртэл ам бүлтэй өрх ядууралд орох эрсдэл бага байхад 6 ам бүлтэй өрхийн хүн ам нийт хүн амын 15,8 хувийг эзлэж байгаа болovч ядуу иргэдийн 21.5 хувь нь 6 ам бүлтэй өрхөд амьдарч байна. Энэ нь өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам амьжиргааны түвшин доошилж байна гэсэн үг юм.

*График 4-4*

**Өрхийн тоо ба ядуурал хамаарал**




Энэ графикаас харахад өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам амьжиргааны түвшин буурах хандлага хот, хөдөөд адилхан ажиглагдаж байна. Мөн 5 ам бүлтэй өрхийн амьжиргааны түвшин ядуурлын шугамд маш ойрхон байхад 6 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн амьжиргааны түвшин буурч, ядууралд өртөх магадлал ихтэй болж байна. График 4-4 -өөс харахад 6 ам бүлтэй өрхөд амьдрагчдын 48.5 % ядуу амьдралтай байхад 7 ам бүлтэй бол 57.4%, найм ба түүнээс дээш ам бүлтэй бол 70 орчим хувь нь ядрууалд өртөх магадлалтай байна. 3 ам бүлтэй өрхийн 17%, 4-5 ам бүлтэй өрхийн 23% - 35%, 5-7 ам бүлтэй өрхийн 58%, 8 дээш ам бүлтэй өрхийн 68% нь амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой амь зууж байгаа бол 1-2 ам бүлтэй өрхийн ядууралд орох магадлал маш бага 2-8 хувьтай байна.

Энэ нь ам бүлийн тоо өсөх тусам ядууралд өртөх нь ихсэж, ам бүлийн тоо амьжиргааны түвшинд урвуу хамааралтай болох нь тогтоогдож байна.

**б. Өрхийн амьжиргаанд үзүүлэх ам бүлийн тооны нөлөөллийн үнэлгээ:**

Дээр дурдснаар 5- аас дээш ам бүлтэй өрхөд амьдрагчдын нийт хүн амд эзлэх хувийн жин багасаж байхад тэдний ядуучуудын дунд эзлэх хувийн жин нь өсөж байна. Ам бүлийн тоо амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгааг эрсдлийн коэффицент болон үнэлгээний аргачлалын дагуу тодорхойлж болно.

"Ядууралд өртөх эрсдлийн коэффициент" /Кэ/ нь тухайн тооны ам бүлтэй өрхөд амьдарч байгаа ядуу хүн амын хувийн жин, энэ бүлгийн хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувийн жингийн харьцаагаар дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$K_э = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right)$$

$K_э$ - ядууралд өртөх эрсдлийн коэффициент

$P_{ях}$ - Тухайн тооны ам бүлтэй өрхөд амьдарч байгаа ядуу хүний нийт ядуучуудад эзлэх хувийн жин

$P_{ун}$ - Тухайн тооны ам бүлтэй өрхөд амьдарч байгаа нийт хүн амын улсын нийт хүн амд эзлэх хувийн жин

Эрсдлийн коэффициентыг үндэслэж тухайн өрхийн ам бүлийн тоо амьжиргаанд нь ямар нөлөөл үзүүлж байгааг дараах томъёогоор илэрхийлнэ.

$$Y_n = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right)$$

$Y_n$ - Ам бүлийн тооноос хамаарах амьжиргааны үнэлгээ

Энэ аргачлалаар зарим өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг тодорхойлж үзье.

**4 ам бүлтэй өрх**

$$K_э = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = \left( \frac{23.0 - 15.0}{23.0} \right) = 0.342$$

$$Y_n = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = 1 - \left( \frac{23.0 - 15.0}{23.0} \right) = 0.652$$

4 ам бүлтэй өрхийн ядууралд өртөх эрсдэл харьцангуй бага буюу ядуурлын шугамаас 34.2 %-иар зайтай байна. Үүнээс үндэслээд амьжиргааны үнэлгээ нь «боломж»-ийн амьдрах бололцоотой гэсэн дүгнэлтийг гаргаж байна. Тэгвэл 6 ам бүлтэй өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гаргаж үзье.

**6 ам бүлтэй өрх**

$$K_э = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = \left( \frac{15.8 - 21.2}{15.2} \right) = -0.342$$

$$Y_n = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = 1 - \left( \frac{15.2 - 21.2}{15.2} \right) = 1.342$$

6 ам бүлтэй өрхийн ядууралд өртөх эрсдэл харьцангуй өндөр учраас хасах утгатай гарч байна.Эндээс үндэслээд 6 ам бүлийн амьжиргаанд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ нь 1.342 гэсэн оноо гарч байна. Энэ өрхийн ажил эрхлэлт, боловсрол, орлого олдог хүний тоо зэрэг үзүүлэлтүүд нь хангалтгүй бол ядууралд өртөх магадлал маш өндөр байгааг харуулж байна. Гэх мэтээр бүх өрхийн амьжиргааны түвшинд ам бүлийн тооны үзүүлэх нөлөөлийг тодорхойлж болох юм.

Өрхийн ам бүлийн тооны амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл, ядуурлын хамрах хүрээ 2-ын хамаарлыг дараах графикаас харж болно.

source : http://www.undp.mn/reports/

*График 4-5*

**Ядуурлын хамрах хүрээ ба амьжиргааны үнэлгээний хамаарал**




Дээрх графикаас харахад өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тутам ядуурлын хамрах хүрээ өсөж, амьжиргааны үнэлгээ нь ядуурал руу дөхөж байна. Энэ нь ядууралтай амьжиргааны үнэлгээ шууд хамааралтай болохыг харуулж байна. Тухайлвал: 3 ам бүлтэй өрхөд амьдрагчдын 20% нь ядууралд хамрагдаж байхад 7 ам бүлтэй өрхийн 60 % нь ядууралд өртөж байгаа нь судалгаагаар гарчээ. Тэгвэл 3 ам бүлтэй өрхийн амьжиргааны үнэлгээ 0.431 байгаа нь ая тухтай амьдрах бололцоотойг харуулж байхад 7 ам бүлтэй өрхийн амьжиргааны үнэлгээ нь 1.586 байгаа нь ядууралд өртөх эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Өрхийн ам бүлийн тооноос хамрах амьжиргааны үнэлгээг дараах графикаар харууллаа.

*График 4-6*

**Ам бүлийн тоо ба амьжиргааны үнэлгээ**




*Эх сурвалж: ӨОЗАТС 2002/03*

3 дугаар бүлэгт хийгдсэн тоон судалгаанд манай улсын нийт өрхийн 22.9 % нь 4 ам бүлтэй, 17.9 % нь 3 ам бүлтэй, 17.7 % нь 5 ам бүлтэй байгаа бол 1-2 ам бүлтэй өрх нийт өрхийн 17.1 %-ийг эзлэж байгааг дурдсан.(Хүснэгт №3-4 ) Энэ нь нийт өрхийн 75 орчим хувь нь ядууралд өртөхгүйгээр амьдрах бололцоотойг харуулж байна.

#### *4.3.3.Өрхийн амьжиргааны түвшинд боловсролын нөлөөлөл ба үнэлгээ*

Өрхийн гишүүдийн боловсролын түвшин нь амьжиргааны чадавхийг харуулах нэг гол хүчин зүйл болохыг тоон болон чанарын судалгаагаар батлаж, өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох үзүүлэлтүүдийн нэг болгон сонгон авсан билээ. Энэ үзүүлэлт амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлж, түүнийг яаж үнэлэх аргачлалыг энэ хэсэгт авч үзье.

#### а. Амьжиргаанд боловсролын түвшин нөлөөлөх нь

Хүн амын амьжиргааны түвшинг нэмэгдүүлэх нэгэн чухал хүчин зүйл нь боловсрол юм. Боловсролын түвшин нь иргэдийн амьжиргааны үндсэн эх үүсвэр болж ажилд орох боломжуудыг нэмж өгдөг шууд хамааралтай хэмжигдэхүүн

*График 4-7*

**Боловсролын түвшин ба ядуурлын хамаарал**




Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин бага бол ядуурал өртөх магадлал их, харин боловсрол сайтай бол амьжиргаа нь дээшлэх магадлал өндөр байгаа нь харагдаж байна. Бага боловсролтой өрх хүн амын 14.2 хувийг эзлэж байхад ядуучуудын 17.9 хувь нь эдгээр өрхүүдэд амьдарч байна. Дээд боловсролтой өрх хүн амын 11.6 хувийн эзэлдэг боловч ядуучуудын дөнгөж 3.7 хувь нь тэнд амьдардаг байна. Энэ боловсролын түвшин ядууралтай урвуу хамааралтай гэсэн үг юм.

#### б. Боловсролын түвшингийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

Боловсрол өрх, иргэдийн амьжиргааны түвшинд урвуу хамааралтай юм бол хэрхэн нөлөөлж байгааг нь эрсдлийн коэффицентийг тодорхойлох замаар үнэлж болох юм.

"Ядуурлад өртөх эрсдлийн коэффициент" /Кэ/ нь тухайн түвшний боловсролтой өрхөд амьдарч байгаа ядуу хүн амын хувийн жин, энэ бүлгийн хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувийн жингийн харьцаагаар дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$K_{э} = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right)$$

$K_{э}$ - Ядуурал өртөх эрсдлийн коэффициент

$P_{ях}$ - Тухайн түвшингийн боловсролтой өрхөд амьдарч байгаа ядуу хүмүүсийн нийт ядуучуудад эзлэх хувийн жин

$P_{ун}$ - Тухайн түвшингийн боловсролтой өрхөд амьдарч байгаа нийт хүн амын улсын нийт хүн амд эзлэх хувийн жин

Эрсдлийн коэффицентыг үндэслэж боловсрол өрхийн амьжиргаанд нь ямар нөлөөл үзүүлж байгааг дараах томъёогоор илэрхийлнэ.

$$Y_{n} = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right)$$

$Y_{n}$ - Боловсролын түвшингээс хамаарах амьжиргааны үнэлгээ

Энэ аргачлалаар зарим өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг тодорхойлж үзье.

**1. Дээд боловсролтой өрх .**

$$K_{э} = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = \left( \frac{11.5 - 3.2}{11.5} \right) = 0.678$$

$$Y_{n} = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = 1 - \left( \frac{11.5 - 3.2}{11.5} \right) = 0.322$$

Дээд боловсролтой өрхийн ядуурал өртөх эрсдэл маш бага буюу ядуурлын шугамаас 32.2 пунктын зайтай байна. Үүнээс үндэслээд амьжиргааны үнэлгээ нь «боломж»-ийн амьдрах бололцоотой гэсэн дүгнэлтийг гаргаж байна. Тэгвэл бага боловсролтой өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гаргаж үзье.

**2. Бага боловсролтой өрх**

$$K_{э} = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = \left( \frac{14.2 - 17.2}{14.2} \right) = -0.258$$

Бага боловсролтой иргэний ядуурал өртөх эрсдал маш өндөр байгаа нь

$$Y_{n} = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = 1 - \left( \frac{15.2 - 21.2}{15.2} \right) = 1.258$$

сөрөг тоо гарснаар илэрхийлэгдэж байна. Үүнийг үндэслээд амьжиргааны үнэлгээг дараах байдлаар тодорхойлж болно.

Source: http://www.nso.mn/reports/

Эрсдлийн коэффициент, үнэлгээнээс үзэхэд боловсролын түвшин өндөр болох тусам ядууралд өртөх нь багасаж байна. Бага боловсролтой тэргүүлэгчтэй өрх ядууралд өртөх магадлал нь 1.261 байхад дээд боловсролтой өрх ядуурал өртөхөөс 0.68 пунктээр зайтай байна гэсэн үг юм. Гэх мэтээр боловсролын үзүүлэлтэд сонгон авсан 7 хэмжүүр тус бүрийн амьжиргаанд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг тооцож болно.

*График 4-8*

**Боловсролын түвшин амьжиргааны үнэлгээний хамаарал**




Боловсролгүй эсвэл бага боловсролтой хүн мэргэжлийн ур шаардахгүй, хөдөлмөр багтаамж ихтэй, цалин хөлс харьцангуй бага ажил хийдэг учир амьжиргаанд нь сөрөг нөлөө үзүүлдэг гэсэн дүгнэлтийг чанарын судалгаанаас хийсэн юм. Өрхийн тэргүүлэгчийн боловсролын түвшин өндөр байх тусам ядууралд орох магадлал багасдаг.

***4.3.4. Амьжиргааны түвшинд хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэх нөлөөлөл ба үнэлгээ.***

Амьжиргааны түвшинг тодорхойлогч нэгэн чухал хүчин зүйл бол өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлт юм. Өрхийн хөдөлмөр эрхлэлтийн амьжиргаанд үзүүлж байгаа нөлөөлөл, түүнийг үнэлэх аргачлалыг тодруулан авч үзье.

**а. *Амьжиргаанд хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэх нөлөөлөл.***

Өрхийн гишүүд ямар салбарт ажиллаж байгаагаас амьжиргааны түвшин хамаардаг. Судалгаанаас үзэхэд олон улсын байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газарт ажиллагчдын амьжиргааны түвшин сайн байхад малчид, хувийн секторт ажиллагчдын амьжиргаа ядуурлын шугамын ойролцоо байна. Харин ажилгүй болон хөдөлмөрлөх боломжгүй иргэд ядууралд өртөх магадлал өндөртэй байна.

*График 4-9*




Энэхүү судалгааны тайлангийн 3 дугаар бүлэгт хийсэн тоон судалгааны дүнгээс үзэхэд байгууллага, аж ахуйн нэгжид хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч нийт ажиллах хүчний 42.6 хувийг, хувиараа ажил хөдөлмөр эрхлэгч 52.7 хувийг, ажил олгогч-эзэд дөнгөж 2.1 хувийг эзэлдэг гэсэн тооцоо гарчээ. Харин 2 хүрэхгүй хувь нь гэр бүлийн бизнесд цалин авалгүй оролцдог байна.

**б.Амьжиргааны түвшинд хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэх нөлөөллийн үнэлгээ**

Амьжиргааны түвшинд өрхийн гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал хэрхэн нөлөөлж байгааг дээр дурдсан "тэнцвэржих цэг"-ийн аргаар тодорхойлж болно

"Ядууралд өртөх эрсдлийн коэффициент" /Кэ/ нь тухайн салбарт ажиллагсдын өрхөд амьдарч ядуу хүн амын хувийн жин, энэ салбарын ажиллагсдын өрхөд амьдрагчдын нийт хүн амд эзлэх хувийн жингийн харьцаагаар дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$K_э = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right)$$

$K_э$ - ядууралд өртөх эрсдлийн коэффициент

$P_{ях}$ - Тухайн салбарт ажиллагсдын өрхөд амьдрагч ядуу хүний нийт ядуучуудад эзлэх хувийн жин

$Рун$ - Тухайн салбарт ажиллагсдын өрхөд амьдарч байгаа нийт хүн амын улсын нийт хүн амд эзлэх хувийн жин

Эрсдлийн коэффицентыг үндэслэж тухайн өрхийн ам бүлийн тоо амьжиргаанд нь ямар нөлөөлөл үзүүлж байгааг дараах томъёогоор илэрхийлнэ.

$$Y_n = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right)$$

$Y_n$ - Хөдөлмөр эрхлэлтээс хамаарах амьжиргааны үнэлгээ

Энэ аргачлалаар зарим өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг тодорхойлж үзье.

1. Хувийн секторт гэрээгээр ажиллагч тэргүүлэгчтэй өрх .

$$K_{э} = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = \left( \frac{24.1 - 23.2}{24.1} \right) = 0.047$$

$$Y_{n} = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = 1 - \left( \frac{24.1 - 23.2}{24.1} \right) = 0.963$$

Хувийн секторт гэрээгээр ажиллагчийн өрхийн ядууралд өртөх эрсдэл бага буюу ядуурлын шугамын ойролцоо байна. Үүнээс үндэслээд амьжиргааны үнэлгээгээрээ «дундаж»-ийн амьдрах боломцоотой гэсэн дүгнэлтийг гаргаж болох юм. Тэгвэл улсын секторт ажиллагчийн өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гаргаж үзье.

2.Улсын секторт ажиллагч (цэргийн албан хаагч)-ийн өрх

$$K_{э} = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = \left( \frac{17.9 - 12.8}{17.9} \right) = 0.351$$

$$Y_{n} = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = 1 - \left( \frac{17.9 - 12.8}{17.9} \right) = 0.749$$

Цэргийн албан хаагч тэргүүлэгчтэй өрхийн ядууралд өртөх эрсдэл харьцангуй бага 0.351 гарч байна. Эндээс үндэслээд цэргийн албан хаагчийн өрхийн амьжиргаанд хөдөлмөр эрхлэлтийн нөлөөлөх нөлөөллийн үнэлгээ нь 0.749 гэсэн оноо гарч байна. Энэ нь ядуурлын шугмаас 25 пунктээр зайтай байна гэсэн үг юм.

Тэгвэл ажилгүй өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээг гаргаж үзье.

3.Ажил эрхлэдэггүй өрхийн тэргүүлэгчтэй өрх .

$$K_{э} = \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = \left( \frac{3.0 - 4.0}{3.0} \right) = -0.333$$

$$Y_{n} = 1 - \left( \frac{P_{УН} - P_{ЯХ}}{P_{УН}} \right) = 1 - \left( \frac{3.0 - 4.0}{3.0} \right) = 1.333$$

Ажилгүй өрхийн тэргүүлэгчтэй гэр бүлийн гишүүдийн амьжиргаа ядууралд өртөх эрсдал маш өндөр байгаа нь сөрөг тоо гарснаар илэрхийлэгдэж байна. Үүнийг үндэслээд амьжиргааны үнэлгээг дараах байдлаар тодорхойлж болно. Энэ өрхийн ядуурал өртөх магадлал маш өндөр байна.

Гэх мэтээр бүх өрхийн амьжиргааны түвшинд ам бүлийн тооны үзүүлэх нөлөөлийг тодорхойлж болох юм.

Харин амьжиргааны үнэлгээ нь энэ үзүүлэлтээр тооцсон ядуурлын хэмжээтэй ямар хамааралтай байгааг дараах графикаас харж болно.

Source : http://www.mdp.mn/reports/

*График 4-10*

**Амьжиргааны үнэлгээ ба ядуурлын хамрах хүрээний хамаарал**




Дээрх графикаас харахад ядуурлын хамрах хүрээнээс хамаарч амьжиргааны үнэлгээ өөрчлөгдөж байгаа нь харагдаж байна. Энэ нь амьжиргааны түвшинг тодорхойлохоор сонгож авсан аргачлал үндэслэлтэй, бодит байдалд тохирч байгааг харуулж байна гэсэн үг юм.

*График 4-11*

**Амьжиргааны үнэлгээ ба хөдөлмөр эрхлэлтийн байдал**




Графикаас харахад хувийн хэвшилд гэрээгээр ажиллагч ядуурлын ирмэг дээр амьдарч байхад түр ажилтай болон ажилгүй хүмүүс ядуурал өртөх магадлал ихтэй байна.

### 4.4. Амьжиргаанд нөлөөлөх бусад үзүүлэлтүүдийн ерөнхий үнэлгээ

Өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох шалгуур болгон сонгон авсан бусад үзүүлэлтүүдийг нөлөөлөл, үнэлгээг хийсэн аргачлал үндсэндээ адилхан учраас тэдгээр үзүүлэлтүүдийн эцсийн үнэлгээг товч авч үзье.

***1.Орон сууцны нөхцөл.*** Амьжиргааны түвшинг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүдийн нэгд орон сууцны нөхцлийг нь харгалзан үздэг туршлага олон оронд байна. Зарим орон ганцхан

сууцны нөхцлөөр нь ч амьжиргааны түвшинг үнэлдэг байна. Орон сууцны нөхцлөөс амьдралын боломж, чадавхи нь тодорхойлогддог бөгөөд амьжиргааны түвшин дээшлэх тусам эхний ээлжинд сууцны нөхцлөө сайжруулах арга хэмжээг авдаг гэсэн дүгнэлтийг чанарын судалгаанаас хийж болохоор байна. Монгол орны хувьд гэр сууцны үндсэн нөхцөл болдог уламжлалтай боловч амьжиргаанд үзүүлэх нөлөөлөл нь хот, хөдөөд харилцан адилгүй байна. Хөдөөд гэртэй өрх ердийн амьдарч байхад хотын гэрт амьдарч байгаа өрх ихэнхдээ ядууд орж байгаа нь ӨОЗАТТС-ны дүнгээс харж болох юм.

*График 4-12*

**Сууцны нөхцлийн үнэлгээ**




Графикаас харахад тохилог сууц, байшинд амьдарч байгаа өрхүүдийн амжиргааны түвшин өндөр байхад сууцны бус байшин, хотын гэр, айл, орц хонгилд амьдрагчид ядууралд өртөх эрсдэл ихтэй гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

***2. Хөрөнгө.*** Өрхийн амьжиргааны эдийн засгийн чадавхийн нэг хэмжүүр бол үл хөдлөх хөрөнгө, бизнесийн орчин байдаг. Манай орон зах зээлийн харилцаанд шилжээд удаагүй байгаа боловч бизнесийн ажиллагаа эрхлэх амьжиргааны нэг эх үүсвэр болжээ. Иймээс амьжиргааны түвшинг үнэлэхдээ хувийн компани, дэлгүүр, гуанз, хадгаламж зэрэг хэмжүүрүүдийг авсан юм . Тухайн өрхийн орлого нь зарлагаасаа давж байвал хүмүүс түүнийгээ хадгалдаг учраас өрхийн баялагын нэг үндсэн хэсэг нь мөнгөн хөрөнгө юм. Мөнгөн хөрөнгөтэй өрхийн ядууралд өртөх магадлал бусад өрхүүдээс 2 дахин бага байдаг байна.

*График 4-13*

**Амьжиргаанд бизнесийн үзүүлэх нөлөөлөл.**




График 4-13 –аас харахад хувийн бизнес эрхлэгчид болон хадгаламжтай хүмүүсийн амьжиргаа сайн байхад бизнес эрхлэдэггүй хүмүүсийн амьдрал төдийлэн дордохооргүй байна.

***3. Өрхийн орлоготой гишүүдийн тоо.*** Өрхийн байнгын орлоготой гишүүдийн тооноос хамаарч амьжиргааны түвшин өөрчлөгдөх нь судалгаагаар тогтоогдсон. Гэхдээ байнгын орлогод цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж , үйлчилгээ, худалдааны орлогыг харуулах боловч орлогын доод хэмжээ нь тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод түвшингийн 50%-иас багагүй нөхцөлд энд хамруулна. Маш бага хэмжээний тэтгэмжтэй хүний энд оруулвал үнэлгээ буруу гарах хандлагатай байгаа нь ажиглагдлаа

*График 4-14*

**Өрхийн орлого олдог гишүүдийн тооны үнэлгээ**




***4. Тээвэрийн хэрэгсэл.*** Олон оронд тээврийн хэрэгслийг амьжиргааны түвшинг илэрхийлэх хэмжүүр болгон ашигладаг. Тээвэрийн хэрэгсэл нь амьжиргаа сайтай өрхөд тансаг хэрэглээнд ашиглагдаг бол зарим өрхөд бизнесийн эх үүсвэр болдог.

*График 4-15*

**Тээврийн хэрэгслийн үнэлгээ**




***7. Тусламж, дэмжлэг.*** Өрхийн амьжиргаанд төрийн ба төрийн бус байгууллага, ах дүү хамаатан садангийн үзүүлж байгаа тусламж, дэмжлэг зохих нөлөөлөл үзүүлдэг. Өнөөгийн халамжийн хуулиар нэн ядуу, ядуу амьдралтай иргэдэд нийгмийн халамжийн тусламж үзүүлдэг учраас тэдний амьжиргаа доогуур байгаа нь судалгаагаар гарчээ. Харин гадаадад ажиллаж байдаг хүүхэд, байгууллагаас тусламж авдаг өрхийн амьжиргаа сайн байна. Харин амьжиргааны боломж сайтай өрхүүд бусдаас тусламж авдаггүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

*График 4-16*

**Тусламж, дэмжлэгийн үнэлгээ**




6*. Нийгмийн эмзэг байдал*. Өрхөд байгаа хөдөлмөрийн чадваргүй, байнгын асаргаа, халамж шаардлагатай хүмүүс нь амьжиргааны түвшинд сөрөг нөлөө үзүүлдэг. Ялангуяа хэвтрийн өвчтэй, хараагүй, хэлгүй,сонсголгүй хүмүүс өрхийн амьжиргаанд ихээхэн дарамт учруулдаг гэж судалгаанд оролцогчид хариулсан байна. Түүнчлэн өндөр настан, өнчин хүүхэд зэрэг эмзэг бүлгийнхэн ч амьжиргаанд бэрхшээл учруулах нь бий. Энэ бүхний нөлөөллийг үнэлж амьжиргааны түвшинг тооцоход ашиглах нь чухал ач холбогдолтой. Армени зэрэг

улсуудад ч өрхийн эмзэг байдлын нөлөөллийг амьжиргааны түвшинг тодорхойлохдоо тооцож үр дүнд хүрсэн туршлага байдаг ажээ.

*График 4-17*

**Эмзэг байдлын үнэлгээ**




Эмзэг бүлгийн гишүүнгүй өрхийн амьжиргааны түвшинг  ийм хүнтэй өрхөөс 0.15- 1.0 пунктээр өндөр байх  тооцоо гарсан байна.

Source : http://www.undp.mn

# 5 ӨРХ, ИРГЭДИЙН АМЬЖИРГААНЫ ТҮВШИНГ ТОДОРХОЙЛОХ ШИНЭ АРГАЧЛАЛ БА НИЙГМИЙН ХАЛАМЖ ХҮРТЭГЧДИЙН ТООН ӨӨРЧЛӨЛТ

Судалгааны ажлын эцсийн үр дүн болох өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох шинэ аргалал, нийгмийн халамжийн хамрах хүрээ, үр дүн хүртэгчийн өөрчлөлтийн чиг хандлагын талаар энэ хэсэгт авч үзье.

### 5.1. Өрх, иргэдийн амьжиргааг тодорхойлох шинэ аргачлал.

Өмнөх бүлгүүдэд хийгдсэн судалгааны дүн, сонгон авсан үзүүлэлтүүд, "тэнцвэржих цэгийн арга"-аар тодорхойлсон үнэлгээг үндэслэсэн өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох шинэ хялбаршуулсан аргачлалыг дэвшүүлж байна. Хөгжлийн ижил төстэй олон оронд орлогыг орлуулан тооцох замаар өрхийн амьжргааг тодорхойлох аргыг хэрэглэдэг боловч Монгол орны хувьд анх удаа амьжиргааг өрхийн чадавхиар нь үнэлэх энэхүү аргыг судалгааны багаас дэвшүүлж байна.

***Аргачлалыг боловсруулахад баримталсан шалгуур***:

Өрх иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох шинэ аргачлалыг боловсруулахдаа судалгааны удирдамжид үндсэн болзол болгосон дараах зүйлсийг иш үндэс болгов. Үүнд:

- Мөнгөн ба мөнгөн бус хүчин зүйлүүдэд үндэслэгдсэн байх
- Амьжиргааны түвшинг бодит байдлаар тодорхойлох боломжтой байх
- Амьжиргааны түвшинг тодорхойлоход шаардагдах санхүүгийн нөөцийг бодитой тооцсон байх
- Эргэх холбоо хяналтын тогтолцоо бүхий байх
- Бусад орнуудад хэрэглэгдэж байгаа арга, аргачлалын судалгаанд тулгуурласан байх

***Хэрэглэх хүрээ:*** Энэхүү аргачлалыг иргэдийн амьжиргааны түвшинг тогтоож нийгмийн зүгээс үзүүлэх дэмжлэг, туслалцааны төрөл, хэлбэр, хэмжээг тодорхойлоход ашиглаж болно.

***Үе шат:*** Энэ аргачлалыг хэрэглэхэд 3 үндсэн үе шатны үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг зөвлөж байна.Үүнд:

1. Иргэд өөрсдийн өрхийн талаарх анхны мэдээллийг "Өрх, иргэдийн амьжиргааны түвшингийн асуулга"-ын дагуу үнэн зөв гаргаж өгнө. (Хавсралт 7, " Өрхийн үнэлгээ" гэсэн багана)
2. Баг, хорооны Засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтан зэрэг эрх бүхий албан хаагчид иргэдийн өгсөн анхан шатны мэдээллийн үнэн, зөвийг шалгаж батламжлана. (Хавсралт 7- ын "захиргааны батламжилсан" гэсэн багана)

Source: http://www.undp.mn/reports/

3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг, захиргаа, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан байгууллагын нийгмийн ажилтнууд иргэдийн өгсөн анхны мэдээлэл, энэ аргачлалд тусгагдсан үнэлгээг үндэслэн өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлно. (Хавсралт 8, 9)

***Өрхийн амьжиргааг үнэлэх үйл явц:*** Өрх, иргэдийн амьжиргаанд үнэлгээ өгөх үйл явц нь 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Үндсэн мэдээлэл авах, шалгаж батлах ажиллагаа
2. Өрхийн амжиргааны түвшинг үнэлэх үйл ажиллагаа

**1.Үндсэн мэдээлэл авах, шалгаж батлах ажиллагаа**

Өрхийн тэргүүлэгч болон түүний төлөөлөгч өөрийн өрхийн тухай асуулгад үнэн, зөв хариултыг Хавсралт 7-ын дагуу өгнө. Дараа нь баг, хорооны албан тушаалтан /Засаг дарга, зохион байгуулагч, нийгмийн ажилтан/ үнэн зөвийг шалгаж батламжилна. Энэ хэсэгт дараах асуудлуудад анхаарахыг зөвлөмж болгож байна. Үүнд:

1. ***Өрхийн хаягийн тодорхойлолтууд.*** Өрхийн хаягийн хэсэгт уг өрхийн харьялагдах засаг, захиргааны харьяаллын дагуу аймаг, нийслэл болон сум, дүүргийн нэр, кодыг бичнэ.
2. ***Суурьшилт*** - Өрхийн суурьшлыг засаг захиргааны байршлаас хамаарч нийслэл, аймгийн төв, сумын төв, хөдөөгөөр ялгаж, холбогдох асуулгад байгаа кодыг ашиглан тэмдэглэнэ. Шилжин ирсэн бол хамгийн сүүлд суурьшсан газрыг оруулна.
3. ***Ам бүлийн байдал*** - Өрхийн гишүүдийн нэрсийг өрхийн тэргүүлэгчээс эхлэн дараалуулан бичнэ. Нэрний хаpалдаа арын баганад өрхийн гишүүдийн хувийн дугаарыг бичнэ. Энэ дугаар асуулгын эхэнд тэмдэглэгдсэн байгаа. Өрхийн гишүүдэд тухайн жилийн туршид гэртээ амьдраагүй, гэрээс алс суралцагсад, цэргийн алба хаагчдыг бүртгэхгүй. Харин тухайн өрхөд түр хугацаагаар (6 сараас дээш хугацаагаар) амьдарч, хамтарч, хооллож, хувцаслаж байгаа хүмүүсийг өрхийн гишүүнд бүртгэнэ.
4. ***Хөдөлмөр эрхлэлт*** - Өрхийн 16 нас хүрсэн гишүүдийг ажилтай, ажилгүй гэж ангилж бичнэ. Ажилтайд - Аж ахуйн нэгж, байгууллагын орон тоонд ажиллагч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, хамтран ажил гүйцэтгэгч, өрхийн аж ахуй эрхлэдэг хүмүүс, малчид, мөн ажилтай мөртлөө тодорхой шалтгаанаар (өвчтэй, цаг агаарын байдал, амралт г.м) түр ажил эрхлээгүй байгаа хүмүүсийг ажилладаг байгууллагын төрлөөр хамруулна. Түүнчлэн хувийн жижиг бизнес эрхэлгчид, албан бус секторт үйдвэрлэл худалдаа хийгчид, улирлын болон түр ажилтай хүмүүс ажилтайд тооцогдоно.

***Ажил эрхлээгүй хүмүүст :***

***Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн ажилгүй -*** Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, тухайн үед ажиллахад бэлэн, ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүсийг хамруулна.

***Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлээгүй ажилгүй -*** Аж ахуйн нэгж, байгууллагын орон тоонд ажилладаггүй, хөдөлмөр эрхлэлтийн албаны ажилгүйчүүдийн бүртгэлд бүртгэгдээгүй, хувиараа хөдөлмөр эрхэлж, орлого олдоггүй хөдөлмөрийн насны хүнийг хамруулна. Гэхдээ үүнд бүх шатны сургуульд өдрөөр суралцагчид, хугацаат цэргийн албан хаагчид, хоригдол, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй хүмүүс орохгүй.

5. ***Өрхийн боловсролын түвшин*** - Өрхийн гишүүдийн боловсролын хамгийн өндөр түвшингээр тодорхойлогдох бөгөөд мэргэжлийн анхан шат (МАШ)-ны боловсролд

ТМС, МСҮТ, мэргэжлийн лицей төгсөгчдийг, “тусгай дунд “ гэдэгт техникум, коллежи төгссөн хүмүүсийг “дээд” гэдэгт их, дээд сургууль, коллежийг баклавар, магистр, докторын зэрэгтэй төгссөн хүмүүсийг оруулна.

6. ***Орон сууцны нөхцөл*** – Сүүлийн 6 сарын хугацаанд амьдарч байгаа сууцны төрлөөр бичнэ. Тохилог сууцанд цахилгаан, халаалт, усан хангамж, сувагжилттай байрууд хамаарах бол сууцны байшинд орон сууцны зориулалтаар барьсан жижиг байрууд орно. Нийтийн сууцанд оюутны дотуур байр, ажиллагчдын байр болон нийтийн зориулалтаар баригдсан сууцууд хамаарна. Сууцны бус байранд үйдвэрлэл, үйлчилгээний зориулалттай, амьдрахад тохиромж муутай байрууд, дулаалга, халаалтгүй зуны сууц (өвөл амьдардаг) зэрэг орно.
7. ***Хөрөнгө*** **-** Мөнгөн хөрөнгөнд хадгаламж, үнэт цаас, бонд, хувьцаа, бусдад зээлсэн мөнгө, бэлэн мөнгөний хуримтлал зараг хамаарна. Бэлэн мөнгөний хуримтлалд өдөр тутмын хэрэгцээнээс гадна тусгай зориулалтаар ашиглахаар хурмтлуулж байгаа мөнгө орно. “Мал” гэсэн хүснэгтэнд бодод шилжүүлснээр 9-аас дээш толгой малтай өрх хариулна. 0.67 тэмээ, 8 ямаа, 6 хонь тус бүр нэг бодтой тэнцэнэ. Харин хөдөө амьдрагчдын хувьд малын толгойн тоог тусгай үзүүлэлт болгон авсан. “газар” гэсэн асуултанд өөрийн эзэмшлийн газраа эргэлтэнд оруулж мөнгө олж байгаа өрх болон газар тариалан эрхэлж бага боловч ашиг хүртдэг, туслах аж ахуйтай өрхүүд хамаарна.
8. ***Орлого олдог гишүүд*** – Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, хувийн компани, хоршоо, дэлгүүрийн орлого зэрэг бүх хэлбэрийн бэлэн мөнгөний орлоготой хүмүүсийн тоогоор бөглөнө. Гэхдээ сарын орлогын доод хэмжээ хөдөлмөрийн хөлсний 50%-иас багагүй байх нөхцөлд энэ асуудал бөглөгдөнө.
9. ***Тээврийн хэрэгсэл*** - Өрхийн эзэмшилд байгаа тээврийн хэрэгслийн тоогоор бөглөнө Ердийн хөсөгт тээврийн хэрэгслийн зориулалтаар ашигладаг үхэр, морь, тэмээн тэргийг оруулна.
10. ***Тусламж, дэмжлэг*** - нийгмийн халамжийн тусламжид тус сангаас олгодог түлээ, нүүрс, байрны үний хөнгөлөлт, хоол, хүнсны зүйлийг оруулна. Харин тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, нөхөн төлбөр хамаарахгүй. Төрийн бус байгууллагын тусламжинд гурил, будаа, хувцас зэрэг нэн тэргүүний хэрэгцээт зүйлээс эхлээд бүх тусламжууд орно.

**2. Өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх үйл ажиллагаа**

Өрхийн тэргүүлэгчийн гаргаж, баг, хорооны засаг дарга батламжилсан амьжиргааны түвшингийн асуулгыг үндэслэж 11 үзүүлэлтээр үнэлгээ хийхдээ дараах асуудлуудыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

1. ***Суурьшилт*** –Асуулгын эхний хэсэгт бичсэн байнга оршин суудаг газраар холбогдох оноог өгч үнэлнэ.
2. ***Ам бүлийн байдал*** –Асуулгын /хавсралт 7/ эхний хоёр баганад бичигдсэн судалгааг үндэслэж гаргана. Гэр бүлийн нөхөр, эхнэрээс гадна өөрийн төрсөн болон хууль ёсны асрамжинд байх 18 хүртэлх насны хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй хамт амьдардаг эцэг эх зэрэг хамт хооллож, нэг өрхөд амьдардаг хүмүүсийг хамруулна.
3. ***Өрхийн боловсролын түвшин*** - Өрхийн гишүүдийн боловсролын хамгийн өндөр түвшингээр тодорхойлогдох бөгөөд хөдөлмөрийн насанд хүрсэн, суралцдаггүй гишүүдийг хамруулж боловсролын “дундаж” түвшинг гаргана

Source: http://www.mcp.mn/reports/

4. ***Өрхийн хөдөлмөр эрхлэлт*** - Тэтгэвэрт байгаа хүнийг “ажил эрхлээгүй шалтгаан” гэсэн хүснэгтээс нөхнө. Өрхийн зөвхөн хөдөлмөрийн насанд хүрсэн, ажиллаж байгаа буюу ажилгүй хүмүүсийн “дундаж” – оноогоор энэ үзүүлэлтийг үнэлнэ.
5. ***Орон сууцны нөхцөл*** - Сүүлийн 6 сарын хугацаанд амьдарч байгаа сууцны төрлөөр үнэлнэ.
6. ***Тээрийн хэрэгсэл*** - Үнэлгээг хийхдээ олон төрлийн тээврийн хэрэгсэл байгаа бол өрхөд байгаа тээврийн хэрэгслүүдээс эхэнд бичигдснийг / автомашин/ сонгож асуулгын үнэлгээг хийнэ.
7. ***Өрхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд*** - Өрхөд байгаа тахир дутуу иргэдийн тоогоор бөглөх бөгөөд /хавсралт 7/ -ын ажил эрхлээгүй шалтгаан гэсэн хэсэгт бичигдсэн хөдөлмөрлөх боломжгүй, амьжиргаанд хүндрэл, бэрхшээл учруулдаг өрхийн гишүүнийг хамруулж үнэлнэ.
8. ***Өрхийн эмзэг байдал*** - Байнга архи ууж дарамт үүсгэдэг гишүүн, өнчин хүүхэд, бие даан амьдрах чадваргүй өндөр настан, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэг зэрэг /хавсралт 7/-д бичигдсэн хүмүүсийг хамруулж үнэлнэ.

***Үнэлгээ:*** Иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох асуулгын хариултыг нарийвчлан шалгаж баг, хорооны дарга нар баталгаажуулсны дараа үнэлгээ өгч амьжиргааны түвшинг нь тодорхойлно. Үүнд:

1. Үнэлгээний коэффициент нь хот, хөдөө гэсэн ангиллаар ялгаатай тул харгалзах оноог нь өгнө
2. Асуулгын хариултыг тусгай программ бүхий компьютерт оруулж нэгдсэн дүнг гаргана.
3. Техникийн нөхцөл хангалтгүй бол 11 үзүүлэлт тус бүрийн үнэлгээний коэффицентуудыг нэмж ердийн арифметик дунджаар тухайн өрхийн амьжиргааны түвшингийн үнэлгээ /АТҮ/ -г гаргана. Харин боловсрол, хөдөлмөр эрхлэлт, тусламж дэмжлэг авалт зэрэг үзүүлэлтүүд дундаж үнэлгээгээр тодорхойлогдохыг анхаарна уу.
4. Амьжиргааны түвшингийн үнэлгээ(АТҮ) 1 бол ядуурлын шугам дээр байна гэж үзнэ.

АТҮ > 1.0 бол ядуу,

АТҮ < 1.0 бол ядуу бус болно.

5. Өрхийн иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлохдоо дараах интервалийг баримтална.

**Өрх, иргэдийн амьжиргааны түвшингийн шатлал**

| Амьжиргааны түвшин | АТҮ |
|---|---|
| 1. Чинээлэг | 0,650-аас бага |
| 2. Боломжийн | 0,651-0,800 |
| 3. Дундаж | 0,801-0,950 |
| 4. Ядуу | 0.951-1,115 |
| 5. Нэн ядуу / Үгээгүй/ | 1,115-аас дээш |

Source : http://www.mdp.mn/reports/

6. Авах дээд ба доод утга: Хотод 0.560 ; 1.347

Хөдөөд 0.620; 1.377

Энэхүү аргачлалыг зөвхөн албан ажлын хэрэгцээнд өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох хэмжүүр болгон ашиглахыг зөвлөж байгаа болно.

### 5.2. Шинэ аргачлалын туршилт, үр дүн

Энэхүү шинэ аргачлалыг 3 аймаг, 2 дүүргийн зарим сум, хороодын 380 орчим өрхөд туршиж зарим үзүүлэлтүүдийг сайжруулах, өөрчлөх, шинэчлэх замаар боловсронгуй болгох ажлууд нийлээд хийгдсэн. Хөдөөгийн сум, багийн захиргаанаас өрхийн нэн ядуу, ядуу иргэдийг тодорхойлсон үнэлгээ энэ аргачлалаар тооцсон үнэлгээтэй үндсэндээ тохирч байхад Улаанбаатарын хороодоос тодорхойлсон үнэлгээ бага зэрэг өөрчлөгдөж нэн ядуу өрхийн нилээд нь ядууд орж, ядуу өрхүүдийн 10-20 хувь нь ядуу бус болох хандлага ажиглагдсан. Гэхдээ сум, хороодод харилцан адилгүй байлаа.

***1. Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сум.*** Энэ сумын 30 өрх шинэ аргачлалын туршилтад хамрагдсанаас багийн даргын “нэн ядуу” гэж тодорхойлсон 16 өрхөөс 11 нь шинэ аргачлалаар тооцсон энэ үзүлэлтэд тохирч 5 нь ядуу руу шилжсэн байлаа. Харин “ядуу” гэж тодорхойлсон 12 өрхөөс ганцхан нь “дундаж” руу шилжиж бусад нь тохирч байна.

*Хүснэгт 5-1*

**Өвөрхангай аймгийн Зүүнбаян – Улаан сумын туршилтын үр дүн**

| | Шинэ аргаар | | Багийн тодорхойлолтоор | |
|---|---|---|---|---|
| | тоо | хувь | тоо | хувь |
| Чинээлэг | | | | |
| Боломжийн | | | | |
| Дундаж | 3 | 10 | 2 | 6.67 |
| Ядуу | 16 | 53.33 | 12 | 40.00 |
| Нэн ядуу | 11 | 36.67 | 16 | 53.33 |
| **Нийт өрх** | **30** | **100.0** | **30** | **100.0** |

***2.Өвөрхангай аймгийн Арвайхээр сум.*** Энэ сумын 110 өрх туршилтанд хамрагдснаас багаас “нэн ядуу” гэж тодорхойлсон 63 өрхийн 10 нь шинэ аргачлалаар энэ шалгуурт тэнцэж, 53 нь “ядуу”-д тооцогдохоор байна Ядуу гэсэн 42 өрхөөс 4 нь “дундаж” гэсэн бүлэгт шилжихээр байна. Нийт дүнгээр нь авч үзвэл амьжиргааны түвшингээс доогуур орлоготой гэсэн 105 өрхөөс 101 нь шинэ шалгуураар энэ үзүүлэлтэнд тохирч байна.

*Хүснэгт 5-2*

**Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын туршилтын үр дүн**

| | Шинэ аргаар | | Багийн тодорхойлолтоор | |
|---|---|---|---|---|
| | тоо | хувь | тоо | хувь |
| | | | | |
| Чинээлэг | | 0.0 | | 0.0 |
| Боломжийн | | 0.0 | | 0.0 |
| Дундаж | 9 | 8.2 | 5 | 4.5 |
| Ядуу | 91 | 82.7 | 42 | 38.2 |
| Нэн ядуу | 10 | 9.1 | 63 | 57.3 |
| **Нийт өрх** | **110** | **100.0** | **110** | **100.0** |

***3. Өмнөговь аймгийн Даланзадгад сум.*** 60 өрх туршилтанд хамрагдснаас “нэн ядуу “ гэсэн 6 өрхийн 5 нь, ядуу гэсэн 31 өрхийн 25 нь шинэ аргачлалаар тооцсон түвшинтэй тохирч байна. Харин боломжийн гэж багаас тодорхойлсон 6 өрх “дундаж” амьдралтайд орсон байна.

*Хүснэгт 5-3*

**Өмнөговь аймгийн Даланзадгад сумын туршилтын үр дүн**

| | Шинэ аргаар | | Багийн тодорхойлолтоор | |
|---|---|---|---|---|
| | тоо | хувь | тоо | хувь |
| Чинээлэг | | 0.0 | 2 | 3.3 |
| Боломжийн | 3 | 5.0 | 9 | 15.0 |
| Дундаж | 27 | 45.0 | 12 | 20.0 |
| Ядуу | 25 | 41.7 | 31 | 51.7 |
| Нэн ядуу | 5 | 8.3 | 6 | 10.0 |
| **Нийт өрх** | **60** | **100.0** | **60** | **100.0** |

***4. Орхон аймгийн Жаргалант сум.*** Энэ сумын 46 өрхөөс ядуу, нэн ядуу гэж 21 өрхийг багаас нь тодорхойлсон бол шинэ аргачлалаар 12 нь энэ үзүүлэлтэнд тохирч байлаа. 9 өрх нь дундаж амьдралтайд орсон бөгөөд хүн амын тоо нэмэгдэж, суурьшилт ихэсэх тусам өнөөгийн аргачлалаар тооцож байгаа амьжирганы түвшингийн үнэлгээ зөрж байгааг сүүлийн 2 сумын дүнгээс харж болох юм.

*Хүснэгт 5-4*

**Орхон аймгийн сумын туршилтын үр дүн**

| | Шинэ аргаар | | Багийн тодорхойлолтоор | |
|---|---|---|---|---|
| | тоо | хувь | тоо | хувь |
| Чинээлэг | 4 | 8.7 | 1 | 2.2 |
| Боломжийн | 12 | 26.1 | 8 | 17.4 |
| Дундаж | 18 | 39.1 | 16 | 34.8 |
| Ядуу | 12 | 26.1 | 18 | 39.1 |
| Нэн ядуу | | 0.0 | 3 | 6.5 |
| **Нийт өрх** | **46** | **100.0** | **46** | **100.0** |

***5. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо.*** 53 өрх туршилтанд хамрагдсанаас 45 өрх нэн ядуу, ядуу гэж тодорхойлогдсон бол шинэ аргачлалаар 35 нь энэ үзүлүлэлтийг хангаж 10 нь дундаж амьжиргаатайд шилжсэн байна. Гэвч нэн ядуу гэж хорооноос үзсэн 27 өрх бүгд “ядуу”-д тооцогдож байгааг анхаарч нарийвлан судлах ажлыг үргэлжлүүлэн хийв.

*Хүснэгт 5-5*

**Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн туршилтын үр дүн**

| | Шинэ аргаар | | Багийн тодорхойлолтоор | |
|---|---|---|---|---|
